

ХУУЛЬ ТОГТООМЖ, ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ, ЗАСГИЙН
 ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН
 (2010 оны жилийн эцсийн байдлаар)

2011.01.10

Баянхонгор

	Бүгд	Үүнээс						Албан даалгавар	
		УИХ-ын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл		
Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	69				54		15		
Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	104				78		26		
Үүнээс	Биелсэн 100%	68			47		21		
	Хэрэгжих шатандаа	36			31		5		
	Үүний дотор	90.0%	25			20		5	
		70.0%	5			5			
		50.0%	2			2			
		30.0%	2			2			
		10.0%							
	Хугацаа болоогүй	2			2				
	Тасарсан								
Үүнээс:	Зохион байгуулалтаас				d				
	Хөрөнгө дутагдсанаас								
Биелэлтийн дүн /хувь/	94.0				90.0		98.0		

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ /ТОВЧОО/
(2010 оны жилийн эцсийн байдлаар)**

2011.01.10

Баянхонгор

№	Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр					
	Он, сар, өдөр	Дугаар	Хяналтад авсан заалтын		Биелүүлэх хугацаа	Биелэлтийн байдал
			Д/д	Дугаар		
0	A	1	2	3	4	5
Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт						
1	2007.9.28	250	1	2		Б-100
2	2010.05.05	105	2	2		Б-100
3	2010.07.20	194	3	2		Б-100
Хөдөө аж ахуй						
4	2007-11-07	283	4	2		Б-100
5	2008 02-27	70	5	5		Б-100
6	2008.03.05	84	6	2		ХШ-90
			7	5		Б-100
7	2009.07.08	208	8	2		Б-100
8	2010.02.10	34	9	3		Б-100
9	2010.01.11	7	10	5		Б-100
10	2010.03.03	52	11	3		Б-100
			12	4		Б-100
11	2010.03.10	60	13	2а		Б-100
			14	2б		Б-100
12	2010.06.02	137	15	2		ХШ-90
			16	3.1		ХШ-70
			17	3.2		Б-100
			18	3.3		Б-100
			19	3.4		ХШ-90
			20	3.5		ХШ-70
			21	4		Б-100
13	2010.07.07	166	22	2		Б-100
			23	4		Б-100
			24	4.б		Б-100
			25	4.в		Б-100
			26	4.д		ХШ-50
			27	4.е		Б-100
			28	4.ж		ХШ-90
			29	4.з		ХШ-90
			30	4.и		Б-100
14	2010.07.20	197	31	2		Б-100
15	2010.09.01	223	32	3		ХШ-90
			33	4		Б-100
16	2010.09.01	222	34	2		Б-100
Байгаль орчин						
17	2009.07.22	227	35	2		ХШ-90
18	2010.03.10	59	36	3		ХШ-90
19	2010.04.14	90	37	3.а		ХШ-30

			38	3.6		Б-100
Үйлдвэрлэл худалдаа хүнсний хангамж						
20	2005-3-9	44	39	7		ХШ-90
21	2009.02.04	32	40	3		ХШ-70
			41	4		ХШ-70
22	2009.06.10	173	42	2		ХШ-90
23	2009.12.30	37	43	4		ХШ-50
24	2010.06.02	138	44	4		ХШ-70
			45	5		Хугацаа болоогүй
Дэд бүтэц барилга хот байгуулалт						
25	2006-08-02	191	46	2		Б-100
26	2007-10-31	282	47	5.а		Б-100
			48	5.в		ХШ-90
27	2009.05.27	157	49	5		Б-100
28	2010.07.07	188	50	5		ХШ-90
29	2010.07.14	190	51	2		Б-100
30			52	2		ХШ-90
Эрүүл мэнд, спорт						
31	2009.01.07	5	53	6.1		Б-100
32	2009.09.30	303	54	2		Б-100
33	2009.07.14	211	55	1		Б-100
34	2009.12.30	374	56	2		Б-100
35	2009.07.29	239	57	2		ХШ-90
36	2010.02.17	43	58	3		ХШ-90
37	2010.08.18	210	59	2		ХШ-90
Боловсрол, соёл, шинжлэх ухаан						
38	2009.01.28	23	60	2		ХШ-90
39	2010.02.03	31	61	2		ХШ-90
Нийгэм хамгаалал						
40	2009.04.22	122	62	1		ХШ-90
			63	2		Б-100
41	2009.12.23	371	64	4		Б-100
42	2010.01.06	3	65	8		Б-100
43	2010.06.02	137	66			Б-100
44	2010.04.02	84	67	7		Б-100
45	2010.04.14	91	68	2		Б-100
46	2010.08.18	212	69	4		Б-100
Төрийн захиргаа, удирдлага						
47	2008-01-09		70	3		Хугацаа болоогүй
			71	4		Б-100
48	2008-01-09	7	72	2		Б-100
49	2010.04.14	95	73	2		ХШ-30
50	2010.09.15	237	74	3		Б-100
Хууль хяналт						
51	2009.01.28	28	75	2		Б-100
52	2010.10.06	261	76	2		Б-100
Батлан хамгаалах						
53	2008.06.27	272	77	10		Б-100
54	2010.02.17	40	78	2		ХШ-90

Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар
Монгол Улсын Ерөнхий Сайдын захирамж

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж

Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл

Үйлдвэр худалдаа

1	2007-09-19.	44	79	2		ХШ-90
Хууль хяналт						
2	2010.04.07	21	80	4.1		ХШ-90
			81	4.2		Б-100
			82	4.3		Б-100
3	2010.04.07	21	83	1.1		ХШ-90
4	2010.05.19	28	84	3.1		Б-100
			85	3.2		Б-100
			86	3.3		Б-100
Төрийн захиргаа удирдлага						
5	2008.07.22	49	87	3.5		Б-100
6	2008.10.22	59	88	10.5		Б-100
7	2010.02.24	12	89	12.2		Б-100
8	2010.04.28	25	90	2.1		Б-100
			91	2.2		Б-100
			92	2.4		Б-100
9	2010.01.11	3	93	7		Б-100
Санхүү эдийн засаг хөрөнгө оруулалт						
10	2010.01.20 №5	5	94	1.а		Б-100
			95	1.б		Б-100
			96	1.в		Б-100
11	2010.04.14 №21	21	97	4.1.в		Б-100
			98	4.1.г		Б-100
			99	4.3		Б-100
12	2010.05.12	21	100	14.2		Б-100
			101	2.2.		ХШ-90
Эрүүл мэнд спорт						
13	2006-3-22.	12	102	2		Б-100
14	2007-07-04	30	103	10		Б-100
15	2010.01.13	4	104	3.1		ХШ-90

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТБАЯР

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч. ГОМБОДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРЭЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГАД ӨГСӨН ҮҮРГҮҮДИЙН БИЕЛЭЛТИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА
(2010 оны жилийн эцсийн байдлаар)**

2011.01.10

Баянхонгор

№	Эрх зүйн актын нэр, он, сар, өдөр	Холбогдох зүйлийн заалт	Заалтын биелэлтийн явц байдлын тухай тэмдэглэл
Монгол Улсын Засгийн газрын тогтоол			
Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт			
1	Ахмад дайчдын орон сууцны тухай 2007-9-28 № 250	2.Ахмад дайчдын орон сууцны хангамжийг сайжруулахад зориулж тодорхой хэмжээний хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусган шийдвэрлэж байхыг ... сайд аймаг... Засаг даргад даалгасугай	2010 оны байдлаар ахмад дайчин Д.Лувсан, Ц.Соонуу, Н.Сандаг, Л.Цолмон Ч.Лувсанцэрэн, Д.Долгор, Д.Аюуш, Ц.Жанцан, Г.Батдэлгэр, Г.Готов, Д.Жамц, Г.Жамц, Ч.Дорж, О.Готов, О.Ядамжав нар Улаанбаатар хотод байр авсан байна. Нийгмийн халамжийн хуулийн хүрээнд заасан бусад тэтгэмж тусламжийг шуурхай хүргэж байна. /Биелсэн 100%/
2	Хөрөнгө гаргах тухай 2010.05.05 №105 /Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгын засвар/	2. Засгийн газрын нөөц сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан тайланг гаргаж Онцгой байдлын ерөнхий газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга нар, –д тус тус даалгасугай.	БСШУЯ-наас эрх шилжиж, тушаал 2010 оын 6-р сарын 8- нд ирсэн. Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгын засварын тендерийг зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан "МЦ-Энх" ХХК ажлаа 100 хувьтай гүйцэтгэж нөөц сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан тайланг Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн. Барилгын засварын ажлыг улсын комисс хүлээж аван ашиглалтын явц хэвийн байна. /Биелсэн-100%/
3	Төсвийн хязгаар батлах тухай 2010.07.20 №194	2.Батлагдсан төсвийн хязгаарт багтаан 2011 оны төсвөө боловсруулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай	2011 оны орон нутгийн төсвийн төслийг төсвийн 5,5 төгрөгийн хязгаарт багтаан боловсруулж Сангийн яаманд хянуулсан бөгөөд аймгийн төсвийн нийт зарлагыг 6,6 тэрбум төгрөгөөр батлуулсан. /Биелсэн -100%/
Хөдөө аж ахуй			
4	Хөтөлбөр батлах тухай /Малын тэжээл/ 2007-11-07 №283	2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2008 оноос эхлэн нийгэм эдийн засаг, хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байхыг...Засаг дарга нарт даалгасугай.	“Малын тэжээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, иргэдийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж байна. Хадлангийн талбай сайжруулах тэжээлийн ургамал тариалах төсөлд Өлзийт, Бөмбөгөр, Шинэжинст сум шалгарч улсын төсвийн 24 сая төгрөгийн санхүүжилтээр 32.4 га талбайг хадлан нөөц бэлчээрийн зориулалтаар хашиж хамгаалав. Малын тэжээл хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж жил бүрийн эдийн засаг нийгмийн чиглэлд тусган хэрэгжүүлж байна. Малын тэжээл бэлтгэх, өвс тэжээл худалдан авах зардалд 2009-2010 онд 100 гаруй сая төгрөг зарцуулаад байна. / Биелсэн -100%/

5	Хөтөлбөр батлах тухай. 2008 02-27 №70 /Атрын 3 дахь аян/	5. Орон нутгийн онцлогт тохируулан “Атрын гурав дахь аян”- тариалангийн хөгжлийн дэд хөтөлбөр боловсруулан үр дүнг жил бүрийн 2-р сарын 1-ний дотор ХХААЯаманд ирүүлж байхыг ... Засаг дарга нарт үүрэг болгосугай	Газар тариалан сүүлийн 10 жилд сэргэж, тариалах талбайн хэмжээ 5 дахин хураан авсан ургац 2100 тонноор нэмэгдэж, 2010 онд 26 аж ахуй нэгж 1409 өрх, иргэн 533.2 га талбайд үүний дотор арвай 5.1, төмс 271.8 хүнсний ногоо 136.6 /үүний дотор жимс, жимсгэнэ 11.5га/, тэжээлийн ургамал 120.4, талбайд тус тус тариалж 11.7 тн арвай, 2418.6 тн төмс, 1218.9 тн хүнсний ногоо, 359 тн тэжээлийн ургамал хураан авлаа.“Атрын гурав дахь аян”- тариалангийн хөгжлийн дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлсний үр дүнд өнгөрсөн оныхоос тариалсан талбайн хэмжээ 2010 онд 48,3 га –аар, хураан авсан ургац 560 тонноор тус тус нэмэгдэж, тэжээлийн ургамал, чацаргана тариалах иргэн, аж ахуйн нэгжийн тоо өссөн байна. Иргэд, аж ахуйн нэгжийн идэвхи, санаачилга, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслийн дэмжлэгтэйгээр 3780 м ² талбай бүхий 62 хүлэмж шинээр баригдаж, одоогоор 7171м ² талбай бүхий 190 том, жижиг хүлэмж ашиглагдаж байна Биелсэн -100%
6	Хөтөлбөр батлах тухай 2008.03.05 №84 /Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах/	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусган, бүс нутаг, салбар хоорондын уялдааг ханган ажиллаж, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, биелэлтийг нь хангах арга хэмжээ авч байхыг Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчны сайд Г.Шийлагдамба, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон, Хүнс, Хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Төвлөрсөн болон төвлөрсөн бус 380 усан хангамжийн цэг байгууламжид лабораторийн шинжилгээтэй хяналт шалгалтыг 45 удаа хийлээ. Нийт лабораторийн шинжилгээний 66,6% нь нянгийн бохирдолттой байна. Бохирдолтын гол шалтгаан нь эрүүл ахуй хамгаалалтын бүс байхгүй, Баянхонгор сумын цэвэр усны байгууламж нь цэвэршүүлэх төхөөрөмж байхгүй байгаатай холбоотой байна. Холбогдох газруудад улсын байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хянан ажиллаж байна. Мөн аймгийн 2011 оны үндсэн чиглэлд дээрх асуудлыг орууллаа. / Хэрэгжих шатандаа-90%/
		5.Химийн хорт бодисоор бохирдсон хөрс, талбайг нөхөн сэргээх ажлыг 2008 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай	Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд санал тавьж энэ ажлын үр дүнд 9-р сард Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналтын дор “Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөл ”-өөс гаргасан зөвлөмжийн дагуу Онцгой байдлын ерөнхий газар Баацагаан, Баян-Овоо, Бөмбөгөр, Баянлиг, Галуут, Жинст, Шинэжинст, Бууцагаан сумдын нутагт байгаа нийт 28 цэгт саармагжуулалт, хоргүйжүүлэлт хийж, нийт 28 цэгээс 2161 м2 буюу 3258 тонн шлам, хаягдлыг Баян-Овоо сумын нутагт байрлах Цагаан цахирын уурхайн хаягдлын санд төвлөрүүлэв. Тухайн цэгүүд дээр зүй бусаар химийн хорт бодис ашиглаж байгаль экологийн хохирол учруулж түүнийг аюулгүй болгоход гарсан зардлыг тооцоолж холбогдогчийг хуулийн байгууллагад шилжүүллээ. / Биелсэн 100%/
7	Төрөөс малчдын талаар	2.Төлөвлөгөөнд заасан арга хэмжээ,	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг аймгийн нийгэм, эдийн засгийг 2010

	баримтлах бодлогын эхний үе шат /2009-2015/ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2009.07.08 №208	санхүүгийн үүсвэрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж биелэлтийг тухай бүр мэдээлж байгаа. МАА-н өвөлжилт, хаваржилтыг даван туулах, малчид оторчдод төрийн үйлчилгээ хүргэх, бог малын хээлтүүлэгч гаднаас авах, бэлчээрийн сан, тэжээлийн сан, байгуулж малчдыг эрсдлээс хамгаалах зэрэг үр дүнтэй арга хэмжээг авч энэ оны төсөвт өвөлжилт хаваржилтыг даван туулах хөтөлбөрийн 250,0 сая, гамшгаас хамгаалах санд 25,0 сая, 2009 оны төсвийн давсан орлогоос 45,3 сая нийт 320,3 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулав /Биелсэн -100%/
8	Хөрөнгө гаргах тухай 2010.02.10 №34	3.Олгосон хөрөнгийг тогтоолын хавсралтад заасан зориулалтын дагуу зарцуулан, гүйцэтгэлийн тайланг гаргаж холбогдох баримтын хамт 2010 оны 5 дугаар сард багтаан Сангийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газраас хуваарилсан 230.0 сая төгрөгийг дараах зүйлд зарцуулсан. Үүнд: 1. Хорголжин тэжээл, өвс худалдан авах, тээвэрлэхэд 150.836.100 төгрөг 2. Үхсэн малын сэг зэм, устгахад 28.144.900.төгрөг 3. Малын эм тариа, био бэлдмэл худалдан авахад 29.619.000 төгрөг 4. Тэжээлийн арвай будаа тээвэрлэж ирэх зардал 5. Онцгой байдлын хэлтэст сэг зэм устгалын бензинд 1.400.000 төгрөг тус тус зарцуулаад байна. Тайланг 2010 оны 5 дугаар сарын 17-нд 2/555 тоот албан бичгийн хамт Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. /Биелсэн-100%/
9	Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2010.01.11 №07	5.Улсын нөөцөөс хөнгөлөлттэй үнээр худалдах өвс, тэжээлийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай	Хөгжлийн бодлогын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газрын хяналт зохицуулалтын хүрээнд ямар нэгэн зөрчил дутагдалгүй, хүрэлцээ боломжоор нь бүх сумдад хуваарилж өвс тэжээлийг малчин өрхөд хөнгөлттэй үнээр олгов. Өвс тэжээлийн татан авалт тараалтын талаар тайлан гаргаж Засгийн газар , ОБЕГазарт хүргүүлэв. /Биелсэн-100%/
10	Малын сэг, зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний тухай 2010.03.03 №52	3.'Хөрөнгө гаргах тухай' Засгийн газрын 2010 оны 2-р сарын 10-ны өдрийн 34-р тогтоолын дагуу Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Увс, Төв, Хөвсгөл аймгуудад олгосон хөрөнгийн бусад арга хэмжээний зардлаас 25.0 /хорин таван/ сая төгрөгийг нь малын сэг, зэм устгахад	Аймгийн 20 суманд 362 цэгт малын сэг зэмийг устгал хийж 305261м ² талбайд 9.0 тонн хлорын шохой, 1500 литр павидион иод зэрэг ариутгалын бодис ашиглаж ариутгал халдваргүйтэл хийн тус ажилд нийт 47.270.000 төгрөгний зардал гарч, түүнээс авто машин 77, ердийн хөсөг 5, трактор 2, бусад 5, бүгд 89 тээврийн хэрэгсэл ажиллан, 10614 км замыг 13121 литр бинзенээр туулан тээврийн хэрэгсэл, шатахууны нийт үнэ 21.400.000 төгрөгийг зарцуулсан байна. /Биелсэн- 100%/

		шаардагдах тээврийн хэрэгсэл, шатахууны зардалд зарцуулахыг дээрх аймгийн Засаг дарга нарт даалгасугай	
		4. Олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан гүйцэтгэлийн тайланг гаргаж холбогдох баримтын хамт 2010 оны 5-р сард багтаан Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд тус тус ирүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай	Тайланг 2010.05.17-нд 2/555 тоот албан бичгийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. /Биелсэн- 100%/
11	Хөтөлбөр батлах тухай 2010.03.10 №60 /Чацаргана хөтөлбөр/	2а.Хөтөлбөрийн зорилт арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай	Хөтөлбөрийн хүрээнд чацаргана тариалах иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас санал авч судалгаа явуулан дэд хөтөлбөр боловсруулан санхүүжилтийг шийдвэрлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 11 сумын 4 аж ахуйн нэгж, 17 иргэн 45.1 га талбайд 56 мянга гаруй чацаргана тариалаад байна. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөнгөлттэй зээлийн хүрээнд 15 сая төгрөгийг чацарганы аж ахуй байгуулах 2 төсөлд олгож байна. 2010 онд 2 аж ахуйн нэгж, 10 иргэн 18.6 га-д 23.5 мянга шахам чацаргана тарьж ургуулаад байна. /Биелсэн -100%/
		2б.Хөтөлбөрийн зарим арга хэмжээг олон улсын байгууллагын зээл, тусламж. Гадаад оронтой тогтоосон хоёр болон олон талт хамтын ажиллагааны төсөл арга хэмжээнд хамруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсугай	- Дэд хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Япон улсын Зүүн өмнөд Азийн ногоон байгууламжийг хамгаалах нийгэмлэг /тэргүүн Сасаки Ичиро/-тэй хамтран Эхийн голд 3 га мод үржүүлгийн газар байгуулж, 250х138 метрийн талбайг хашаалан 207 чацарганыг суулгац, мөчрөөр тариалав. Дэлхийн зөн Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр Баянцагаан, Жинст, Богд болон бусад сумын 63 өрх, иргэн нийт 3,3 га талбайд 4100 суулгац, ХХААХҮЯ-ны “Чацаргана” төслөөр Баацагаан суманд иргэн н.Болдхуяг, Эрдэнэцогт суманд иргэн Ж.Батсайхан нар 2500 ширхэг суулгац хураан авсан байна. /Биелсэн100%/
12	2009-2010 оны зудын хохирлыг арилгах зарим арга хэмжээний тухай 2010.06.02 №137	2.Дотоод гадаадын төсөл, хөтөлбөр болон гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламж, зээлийн эх үүсвэрээр малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, тэдэнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, амжиргааны эх үүсвэргүй болсон малчдыг малжуулах, орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний	Төсөвт 40 албан газраас нэг өдрийн цалин 18776578 төгрөг, 41 байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдээс хандиваар 19489150 төгрөг дансанд төвлөрч, 21093350 төгрөгийн бусад эд материал нийт 59359078 төгрөгийн хөрөнгө цугларч сумуудад хуваарилагдан олгогдов. Мөн зарим газраас ирсэн 5297912 төгрөгийн эд барааг ард иргэдэд хуваарилав. ЭМЯ-наас зудтай 13 суманд 8000000 төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгсэл, Бөмбөгөр, Баянбулаг, Баацагаан, Баянговь сумдад нэг бүр нь 16500000 төгрөгийн үнэтэй автомашин, аймгийн эрүүл мэндийн газраас 20 сумын 500 өрхөд нийт 2500000 төгрөгийн эмийн багц, 13 суманд 10900000 төгрөгийн шатахуун, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 8600000 төгрөгийн хүүхдийн хувцас, НҮБ-ын хүн амын сангаас 5600000 төгрөгийн эмнэлгийн

	салбарыг хөгжүүлэх, бичил уурхайд зохион байгуулалттайгаар ажиллуулах зэргээр тухайн орон нутаг бүрт тохирсон ажлын байр бий болгох арга хэмжээ авахыг ... аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	хэрэгсэл, нийт 173600000 төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлжээ “Зуданд нэрвэгдсэн аймгуудад мал аж ахуйд суурилсан амьжиргааг дэмжих онцгой байдлын тусламж” хөтөлбөрийн шугамаар Баянцагаан, Баян-Өндөр, Эрдэнэцогт сумын нийт 299 өрхөд 75826400 төгрөгийн тэжээл, сүү, эмийн багц хүргэгдсэн “АДРА-Монгол” олон улсын байгууллагаас зуданд нэрвэгдсэн Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Жаргалант, Заг, Гурванбулаг, Баянбулаг сумдын 415 өрх бүрд 50000 төгрөгийн хүнсний зүйл, нэг суманд 4400000 төгрөгийн хүн эмнэлгийн салбарт зайлашгүй шаардлагатай эм, бэлдмэл, хөхүүл эмэгтэйчүүд болон нярай хүүхдүүдэд витамин олгосноор дээрхи 5 суманд нийт 42750000 төгрөгийн хандив тусламж очсон байна. /Хэрэгжих шатандаа-90%/
	3.1.Орон нутгаас төв суурин газарт шилжиж ирсэн иргэдэд хашааны газар олгох, хөдөлмөр эрхлэх болон халамжийн чиглэлээр тодорхой дэмжлэг үзүүлэх	Шилжих хөдөлгөөний асуудал шийдвэрлэгдсэн нөхцөлд энэ асуудал шийдэгдэж байгаа болно /Хэрэгжих шатандаа-70%/
	3.2.Малгүй болсон малчин өрхийг малжуулах, бусад салбарт мэргэшүүлэн шилжүүлэх ажлыг сумдын удирдлагатай хамтран зохион байгуулах	Азийн хөгжлийн банкны Ази, Номхон далайн гамшгийн сангаас олгосон тусламжийн 107.1 сая төгрөгний дэмжлэгээр 20 сумын 357 малгүй болсон малчин өрх тус бүрд 300.0 мянган төгрөгний буцалтгүй тусламж олгов. Мөн Засгийн газрын 2010 оны 197 дугаар тогтоолоор баталсан “2009-2010 оны өвөл, хавар тохиолдсон зудын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах түр журам”-ын дагуу улсын төсвийн 113900.0 мянган төгрөгний санхүүжилтээр 10 сумын 67 малчин өрхийг малжуулав. Огт малгүй буюу цөөн малтай өрхийг олон улсын төсөл хөтөлбөрт хамруулан сум, баг дотор нь мал худалдаалах сонирхолтой малчдаас худалдан авч нэг малчин өрхийг 30-аас доошгүй малаар малжуулах, орон нутагт ажиллаж байгаа уул, уурхайн компаниудад гэрээгээр ажилтан болгон элсүүлэх барилгын салбарт туслах ажилтнаар ажиллуулах зэргээр тодорхой арга хэмжээг авч ажиллаж байна /Биелсэн 100%/
	3.3. Олон мал бүхий малчдын малыг түрээсээр маллуулах, гэрээгээр мал өгөх, зэргээр малгүй болсон малчдыг малжүүлэх ажлыг зохион байгуулах	Чинээлэг малчдын дунд туслах малчин шалгаруулан авах ажлыг зохион байгуулж сум бүр дунджаар 3-4 малгүй өрхийг малжуулах арга хэмжээ авснаар 264 малчин өрх гэрээ, түрээсээр ажиллаж байна. /Биелсэн-100%/
	3.4.Малгүй болсон иргэдэд зориулж сургалт явуулан үрээр хангах замаар хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалж ургац хураах, хадлангийн салаа ажиллуулах, тэжээл үйлдвэрлэх, гар тэжээл бэлтгэх, зохион	Энэ онд давхардсан тоогоор 27 мэргэжилтэн 172 хоног томилолтоор сумдад ажиллаж, 3240 малчин, 155 тариаланч, 38 үйлдвэрлэгч нартай биечлэн уулзаж, 15 удаагийн сургалт явуулж, 4203 хүнийг хамруулж, сумын удирдах ажилтан, мэргэжилтний зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлгийг 8 удаа зохион байгуулав. Үүнд малгүй болсон өрх, айлуудыг хамруулсан болно. Сумуудын саналыг үндэслэн тусгай хуваарийн дагуу болсон 17 сумын малчид, төлчдийн зөвлөлгөөнд аймгийн болон хэлтэс, газрын удирдлага, мэргэжилтнүүд

		байгуулалтын арга хэмжээ авч, малчин өрх, баг, сум, аймаг бүр өвс, тэжээлийн нөөцтэй болох ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх	оролцож, цаг үеийн ажлын явцыг эрчимжүүлэх, малчид, тариаланчид, үйлдвэрлэл эрхлэгч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэвшилтэт арга ажиллагаа, шинэ технологийн мэдээллийг сурталчлан таниулах чиглэлээр ажиллав /Хэрэгжих шатандаа-90/
		3.5. Мал ногоолуулах, оторлон таргалуулах, өвөлжүүлж, хаваржуулах ажлыг багийн ИНХ-аар хэлэлцүүлж, өвлийн бэлтгэлийг эртнээс хангах талаар малчин өрх бүртэй гэрээ байгуулж хэвшүүлэн гэрээний дагуу талууд хариуцлага хүлээдэг тогтолцоог бий болгох	Монгол улсын Засгийн газрын 2010 оны 166 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2010 оны 01 тоот албан даалгавар, Засаг даргын 2010 оны 412-р захирамж, 3/858 тоотын дагуу 2010-2011 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг эртнээс ханган малаа ногоолуулах, оторлон таргалуулах, өрх, баг, сум, албан байгууллага бүрт тэжээл бэлтгэх даалгавар авч төлөвлөгөөтэйгөөр ажиллалаа. Мөн өөрийн болон бусад аймгийн нутагт отроор өвөлжиж хаваржих өрхүүдийн судалгааг гарган аймаг сумын Засаг дарга нарын хооронд гэрээ байгуулан тус гэрээнд нутаглах нутаг, өрх, малын тоог тохирох зохион байгуулалтын арга хэмжээ авч байна, /Хэрэгжих шатандаа-70%/
		'4.'Мал аж ахуйн салбарт 2009-2010 оны өвөл, хаврын улиралд тохиолдсон зудын хохирлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө' □-г хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд аймаг нийслэлийн Засаг дарга нарт төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хагас жил тутам Засгийн газарт танилцуулж байхыг ... тус тус даалгасугай	<i>Мал аж ахуйн салбарт өвөл хавар учирсан хохирлыг багасгах, цаашид авах арга хэмжээний талаар:</i> 1.Залуу малчдыг сургалтанд хамруулан мэргэжлийн малчин бэлтгэх, мал маллах ардын уламжлалт ухааныг эзэмшүүлэх 2.Мал болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийг борлуулах, арилжих сүлжээ бүрдүүлэх 3.Мал сүргийг эрүүлжүүлэх, мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдийг бэхжүүлэх, үйлчилгээг чанаржуулах, сүргийн бүтэц өөрчлөгдөж, малын чанар муудаж байгаатай холбоотойгоор үржил селекцийн ажлыг сайжруулах, орон нутгийн уур амьсгалд дасан зохицсон, бэлчээрийн даацдаа тохирсон сүргийн зохистой бүтэц бий болгох зэрэг асуудлуудыг төлөвлөж хэрэгжүүлсний үр дүнд малгүй өрхийг малжуулахад 11.3 сая төгрөг зарцуулаад байна. /Биелсэн -100%/
13	Мал аж ахуйн салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2010.07.07 №166	2.Сүүлийн өдрүүдэд агаарын температур өссөнтэй холбогдуулан хөрс, агаар хэт халж, тариа, бэлчээр гандах төлөвтэй байгааг харгалзан цаг агаарт зориудаар нөлөөлж хур тундас оруулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх малыг зуны оторт гарган таргалуулах, шаарлагатай газарт гангийн зэрэглэл тогтоох зэрэг арга арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт	Агаарын температур өссөнтэй холбогдуулан цаг агаарт зориудаар нөлөөлж хур тундас оруулах ажлыг 2010 оны 5 дугаар сарын 26,27-нд Баацагаан сумын нутагт үүлэнд нөлөөлж хур тунадас оруулах ажлыг амжилттай хийсэн. Цар хүрээг нь нэмж олон удаа хийхээр төлөвлөсөн боловч үүлний бөөгнөрөл шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаагаас шалтгаалан үүлэнд нөлөөлөх ажлыг хийх боломж бүрдэхгүй байсан.Гантай сумуудын малыг таргалуулах болон өвөлжилтийн бэлтгэл эртнээс хангах зорилгоор зуны отрыг хийсний үр дүнд нийт бэлчээрийн 25-аас доошгүй хувийг зун, намрын улиралд малын хөлөөс чөлөөлсөн байна. Малын чанарыг сайжруулах, тоо толгойг нь бэлчээрийн даацад тохируулж өсгөх, мал оторлуулан таргалуулах, эр сувиа, тарга хүч муутай, хөгшин малыг нядалж зах зээлд борлуулах талаар зөвлөгөө, сурталчилгаа хийсэн. /Биелсэн -100%/

	даалгасугай	
	4.Дараах арга хэмжээ авахыг аймаг,нийслэлийн Засаг дарга нарт даалгасаугай А.ОХУ-аас тусламжаар өгсөн арвайгаар тэжээл үйлдвэрлэх болон хадлан, тэжээл бэлтгэх замаар энэ тогтоолын хавсралтаар баталсан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, байршуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах	2010 онд Хүнс хөдөө аж хөнгөн үйлдвэрийн яамны хуваариар 5 тн тэжээлийн ургамлын үрийг сум, тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд олгосноор 120.7 га-д тэжээлийн ургамал тариалж 359 тонн тэжээлийн ургамал хураан авч, Оросын холбооны улсаас тусламжаар өгсөн 500 тонн тэжээлийн арвайг татаж нөөцлөөд байна. /Биелсэн 100%/
	Б.Мал өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагын зүгээс зохион байгуулах үйл ажиллагаа болон малчид, мал бүхий иргэдийн хийх тодорхой ажлыг хамруулсан төлөвлөгөөг аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр баталж , хэрэгжилтийг зохион байгуулан дүнг тухайн шатны ИТХ-ын Тэргүүлэгчидийн хурлаар хэлэлцүүлж, мал өвөлжүүлэх хаваржуулах төлөвлөгөөний хамт Хүнс , хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тайлагнах	Мал өвөлжилтийн бэлтгэл хангах талаар аймаг болон сумууд зохион байгуулж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний шатны тайланг 9 дүгээр сарын 1-ний дотор сум бүрээр гарган үр дүнг тооцохоор цаг үеийн ажлыг эрчимжүүлэх тухай 16/928 аймгийн Засаг даргын албан тоот гарган сум бүрд хүргүүлж, тайлан мэдээг нэгтгэн, аймгийн Засаг даргын өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэн, өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай 335 дугаар захирамжийг гарган ажилласан. Захирамжийн дагуу зуншлага муу байсан говийн сумуудын тодорхой тооны малчин өрх, малын зуншлага сайн байсан зарим сумуудын нутагт өвөлжүүлж хаваржуулах талаар бүсчилсэн уулзалт хийж, гэрээ байгуулах ажлыг хийлгэв. Аймгийн хэмжээгээр бэлтгэх хадлан гар тэжээлийн хэмжээг хадлан 3004,9 тонн, ногоон тэжээл 501 тонн, гар тэжээл 2101,9 тонноор тогтоон аймгийн Засаг даргын тамгын газрын 2010 оны 3/858 тоотойр аймгийн төвийн 110 байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүр 330 ширхэг зоодой, 1 шуудай өвс, 412-р захирамжаар хүн бүр 50 кг өвс бэлтгэхээр төлөвлөн ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 148 дугаар тушаалаар баталсан “Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”-ын дагуу 10-р сарын 20-ны дотор сумуудаас өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалтыг зааврын дагуу хүлээн авахад 4 сум өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангаагүй 16 сум бэлтгэл хангасан, аймгийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалт 80.2%-тай дүн мэдээ гарсан болно. /Биелсэн-100%/
	В. Малын халдварт болон паразит өвчнөөс урьдачлан сэргийлэх,тарилга, угаалга, туулга, зэрэг арга хэмжээг технологийн дагуу цаг хугацаанд нь хийлгэх болон өвөлжөө, хашаа, хорооны ариутгал, халдваргүйтгэлийн ажлын явцад хяналт таьж, үр дүнг	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,8 сая мал хамруулаад байна. Паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ угаалга, туулгалт технологийн дагуу цаг хугацаандаа хийгдэж байна. Аймгийн хэмжээнд одоогийн байдлаар 18561 өвөлжөө, бууц, хашаа, хороо болон захын малын түүхий эд хүлээн авах талбай, малын сэг зэм устгахад 565493 м ² талбайд ариутгал халдваргүйтгэл хийгээд байна. Эдгээр ажлын явцад аймгийн мэргэжлийн хяналтын газартай хамтран 20 сумын 45 мал эмнэлэг үржлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

		тооцож ажиллах	/Биелэсэн 100%/
		Г.Хадлангийн болон тэжээл үйлдвэрлэх техникийн засвар үйлчилгээний ажлыг энэ оны 7 дугаар сарын 20-ны дотор дуусгаж, хадлангийн техникээр үйлчлэх ажлыг зохион байгуулж ажиллах	Тэжээлийн үйлдвэр байхгүй болно. Хасалт хийсэн
		Д.2011 оны хаврын улиралд нийслэл, аймаг төвийн хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор мал бэлтгэж, махыг үйлдвэрийн аргаар боловсруулан нөөцлөх, дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлэх арга хэмжээг холбогдох байгууллага, аж ахуй нэгжтэй хамтран зохион байгуулах	Аймгийн төвийн хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх талаар сум бүрээс борлуулах мал махны судалгааг авсан. Нийт 192.6 мянган толгой мал борлуулах санал малчдаас ирсэн болно. Гадаад дотоодын зах зээлд мал мах борлуулахад туслах талаар ХХААХҮЯ манд санал тавиад байна. /Хэрэгжих шатандаа-50%/
		Е.Хээлтүүлэгч малын тооцоог гаргаж, дутагдалтай байгаа хээлтүүлэгчийг нөхөн тавиулах, худалдан борлуулах, малчид иргэдийн захиалгын дагуу малын зохиомол хээлтүүлгийг зохион байгуулах	Оны эхэнд болон хагас жилийн мал тооллогыг үндэслэн хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог хийсний үндсэнд шаардлагатай байгаа хээлтүүлэгчийн тооцоог гаргасан. Энэ тооцоогоор хуц 3000, ухна 6722, бух 346 толгой шаардлагатай байсныг өсвөр хээлтэгч шинээр нөхөн тавих, гаднаас худалдан авах талаар сумуудад чиглэл өгсөн. Мөн малын зохиомол хээлтүүлэгчийн ажлыг өргөн дэлгэр явуулах талаар зөвлөгөө өгсөнөөс гадна бог малын зохиомол хээлтүүлэгчийн техникч бэлтгэх сургалтанд 10 сум тус бүрээс 1 хүн суулгаж мэргэжил эзэмшүүлсэн. Хээлтүүлэгч малын ялангуяа богийн хээлтүүлэгчийн хүрэлцээ муу учир сум орон нутагтаа цөм сүргийн малаас дутагдаж байгаа хээлтүүлэгчийн 50-аас доошгүй хувийг нь шинээр тавьж бусад аймаг сумаас 200-300 хээлтүүлэгч авсан. Зуншлага муу байсан Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан сумын малчид малын гарга хүч муу байгаагаас цаг хүндэрсэн үед хээлтэгч мал хээлээ даахгүй хоргдол их гарна гэж үзэж бог малыг 100% хээлтүүлэгт оруулахгүй байхаар тооцож саналаа ирүүлээд байна. Бог малын хээлтүүлэгчийг мал эмнэлэг, үржлийн аж ахуйн нэгжид шилжүүлж мэргэжилтний удирдлага хяналтанд оруулахын тулд тэдний үйл ажиллагааг хэвийн явуулах гарааны санхүүжилт олгомоор байна. Учир нь малчдаас хээлтүүлэгч мал худалдан авах санхүүгийн боломж хүрэлцэхгүй байна. /Биелсэн 100%/
		Ж.Бэлчээр, хадлангийн талбай хашиж, уст цэг гаргах, хадлан хадах, тэжээл бэлтгэх, түүхий эд боловсруулах, ахуйн үйлчилгээ үзүүлэх, малын удмын санг хамгаалах, малыг эрүүлжүүлэх зэрэг малчдад туслах чиглэлийн	Улсын хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй уст цэг 8 шинээр гаргах ажлын 50 хувь нь хийгдэж, малчид, иргэдийн санаачилгаар гар худаг 8 шинээр гаргаж, 12 худаг засварлан, хиймэл нуур, усан сан 2-ыг байгуулаад байна. Шинэжинст сумын иргэн Г.Дэмбэрэл, Бөмбөгөр сумын “Мал мөнх” / Г. Бальдир / хоршоо, Өлзийт сумын иргэн н.Түмэнжаргал нар ХХААХҮЯ-ны хадлангийн талбай хашиж, сайжруулах төсөлд шалгарч, булаг, худаг түшиглүүлэн 24 га талбайг хашаалж, тэжээлийн ургамал тариалсны дээр Хүрээмарал сумын

		жигжиг үйлчилгээг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах	иргэн Д. Ганбаатар Их мөрөнгийн голд 400-650м ³ багтаамж бүхий цөөрөм хоёрыг байгуулж 4- 6 га талбайг услах нөхцлийг бүрдүүлээд байна. Усалгаатай талбайн тариалалтын хэмжээ өнгөрсөн оныхоос 57.3 га-аар нэмэгдээд байна. Аймгийн хэмжээнд үсчний 20, зурагчны 14 салбар, оёдол, эсгүүрийн цех 19, төрөл бүрийн засварын газар 26, хэвлэлийн үйлдвэр, цех 8 ажиллаж байна. Аймаг, сумын төвүүдэд ахуйн үйлчилгээ, оёдлын 88 цэг үйл ажиллагаа явуулж байгаагийн дээр энэ оны жигжиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлд гутал засвар, оёдол, гэр ахуйн модон эдлэлийн 4 иргэн, аж ахуйн нэгжийн төслийг хамруулаад байна. /Хэрэгжих шатандаа-90%/
		3.Өвөлжилт хүндэрсэн нөхцөлд малчдад үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах шатахуун болон шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах	Цаг хүндэрсэн үед малчдад үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах шатахууны нөөцийг сум бүрд 500 литр байхаар, эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг 500000 төгрөгөөр тооцон сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд зааснаар бүрдүүлж байна. Мал эмнэлгийн албаны нөөцөд өнөөдрийн байдлаар бадглюмицедин 1000 ширхэг, глюкоз 25 кг тус тус байгаа бөгөөд цаашид нөөцийг нэмэгдүүлэх, шаардлагатай эм хэрэгслийг өгөөд байна. /Хэрэгжих шатандаа-90%/
		И. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг хангалтгүй зохион байгуулж байгаа сум, дүүргийн удирдлага, албан тушаалтантай хариуцлага тооцон ажиллах	Аймгийн Засаг даргын өргөтгөсөн хурлаар сумуудын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангалтгүй зохион байгуулсан Баянбулаг, Бууцагаан сумуудын Засаг дарга нарт 1 сарын цалинг 20 хувиар бууруулах арга хэмжээ авагдсан. /Биелсэн 100%/
14	Түр журам батлах тухай 2010.07.20 №197 /Амжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах/	2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, дүнг оны эцэст танилцуулахыг ... сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Азийн хөгжлийн банкны Ази, Номхон далайн гамшгийн сангаас малгүй болсон иргэдэд үзүүлэх дэмжлэг 107,1 сая төгрөгийн буцалтгүй тусламжид 357 өрх хамрагдлаа. Засгийн газрын 2010 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн “2009-2010 оны зудын хохирлыг арилгах зарим арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоолоор баталсан “Мал аж ахуйн салбарт 2009-2010 оны өвөл, хаврын улиралд тохиолдсон зудын хохирлыг арилгах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилгоор малгүй болсон малчин өрхүүдийг улсын төсвийн хөрөнгөөр малжуулахаар манай аймгийн 9 сумын 67 өрх тус бүрийг 1700.0 мян, бүгд 113900.0 мянган төгрөгөөр санхүүжилт хийгдэн малжуулах ажлыг зохион байгуулж явууллаа. Энэ ажлыг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын 2010 оны 197 дугаар тогтоолоор баталсан “2009-2010 оны өвөл, хавар тохиолдсон зудын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах түр журам”-ыг мөрдөн ажиллав. Манай аймгийн 9 сумаас өрхийн сонгон шалгаруулалтанд тэнцэн, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байсан дадлага туршлагатай, өөрийн гэсэн эзэмшлийн өвөлжөө, хаваржаатай, малаа үр төлөөр нь өсгөж үржүүлэх боломжтой 67 малчин өрхийг сумын Засаг дарга болон амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж, малжуулах санхүүжилтийг сумуудад нь

			шилжүүлэн малжуулах ажлыг зохион байгуулж явуулаа. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчдад малыг нь худалдан авч өгөхдөө мал аж ахуйн мэргэжилтнүүдийг байлцуулан тарга хүч сайтай, төллөх насны, мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдсан эрүүл, үржлийн өсвөр насны хээлтэгчийг шилж сонгон нэг малчин өрхөд саалийн үнээ, эм ямаа, эм хонь оролцуулан 50-60 толгой малаар малжуулсан. /Биелсэн 100%/
15	Сумдад мал эмнэлэг, үржлийн нэгж байгуулах тухай 2010.09.01 №223	3.Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжийн хариуцах ажлын чиг үүргийг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай зөвшилцөн баталж мөрдүүлэхийг Аймгийн Засаг дарга нарт даалгасугай	Сумын Мал эмнэлэг үржлийн тасагт ажиллах мэргэжилтнүүдийн хариуцах ажлын чиг үүргийг ХХААХҮЯамтай зөвшилцөн боловсруулж сумуудад хүргүүлээд байна. /Биелсэн 90%/
		4.Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжийн ажилтныг давтан сургах мэргэшүүлэх тухай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг ... сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Төрийн албаны шалгалтанд ХАА-н мэргэжлийн 69 хүн шалгагдсны 37 нь тэнцсэн бөгөөд мал зүйч, малын эмч ажилтныг давтан мэргэшүүлэх сургалтанд Хөдөө Аж Ахауйн Их Сургуульд 31 хүн хамрагдаж байна. Мэргэжлийн 37 хүн Хөдөө Аж Ахауйн Их Сургуулийн мэргэшүүлэх давтан сургалтанд хамрагдаж байна. /Биелсэн 100%/
16	Төлөвлөгөө батлах тухай 2010.09.01 №222 /Монгол мал хөтөлбөр батлах тухай/	"Монгол мал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамааруулах замаар санхүүжүүлж ажиллахыг ... сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2010 онд Монгол мал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж хөтөлбөрийн санхүүжилт ХХААЖДҮГазарт ирсэн. Үүнд сумдад ажиллах мал эмнэлэг, үржлийн тасгийн 3 орон тоонд ажиллах хүний 3 сарын цалинд 50.9 сая төгрөг, НДШ, ЭМДаатгалд 5.6 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 55.3 сая төгрөгний санхүүжилт ирснийг сумуудад хуваарилан, санхүүжүүлж байна. Сумдын Засаг даргын тамгын газраас албан тасалгаа, ширээ, сандал бусад техник, хэрэгслээр хангаж байна. /Биелсэн 100%/
Байгаль орчин			
17	Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх тухай журам 2009.07.22 №227	2. Ойн сангийн тодорхой хэсгийг энэхүү журмын дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Ойн сангийн тодорхой хэсгийг нөхөрлөл, аж ахуйн нэгжид гэрээгээр эзэмшүүлснээр ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах зорилгоор ой хамгаалах нөхөрлөлийг Эрдэнэцогт суманд 11 нөхөрлөл байгуулж, Галуут сумд 3 Баянлиг сумд 3 Өлзийт сумд 1 нийт 18 нөхөрлөл байгуулан 301926 га талбайг гэрээгээр эзэмшүүлээд байна. / Хэрэгжих шатандаа- 90%/

18	Журам батлах тухай 2010.03.10 №59	3.Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Энэ журмыг ой бүхий сумдад болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлүүдэд хүргэж сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг орон нутагтаа хэрэгжүүлж ажиллахаар чиглэл өгч ажиллаж байна. /Хэрэгжих шатандаа-90%/
19	Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр батлах тухай 2010.04.14 №90	3.а.Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган санхүүжүүлж хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай.	Аймгийн “Цөлжилтийг сааруулах” дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж мөн сумдын саналыг авхаар хүргүүлээд байна. Хөтөлбөр батлагдсаны дараа эхний үе шатын төлөвлөгөөг боловсруулан орон нутагаас тодорхой хөрөнгө шийдвэрлэн хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. /Хэрэгжих шатандаа-30%/
		3.б.Хөтөлбөрийн зарим арга хэмжээг ОУ-ын байгууллагын зээл тусламж гадаад оронтой тогтоосон 2 болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсугай	Швецарын хөгжлийн агентлагийн “Цөлжилттэй тэмцэх” төслийн хүрээнд Баянхонгор сумын ерөнхий боловсролын 6 сургуульд “Ногоон сургууль болгох” уриан доор мод тарьж ургуулан сурагчдад эко сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан байна. Мөн энэ төслийн хүрээнд Жаргалант сумд 200 улиас мод, Бөмбөгөр сумд 100 улиас мод тарьж ургуулсан байна. /Биелсэн-100%/
Үйлдвэрлэл худалдаа хүнсний хангамж			
20	Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2005-3-9 №44	7.Говь, хээрийн бүсэд шахмал түлшний үйлдвэрлэл, эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүчний бусад эх үүсвэрийг ойрын үед шийдвэрлэх чиглэлээр төсөл боловсруулан хэрэгжүүлэх, хот, төв суурин газрын түлээний модны хэрэглээг багасгах арга хэмжээ авахыг,,аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Говь, хээрийн бүсэд шахмал түлшний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аймгийн төв суурин газрын түлшний модны хэрэглээ, агаарын бохирдлыг багасгах зорилгоор Шинэжинст сумын Хотгор дэрсний нүүрсний уурхайг түшиглүүлэн шахмал түлшний үйлдвэр байгуулж, Баянговь, Шинэжинст, Баянхонгор сумдын шахмал түлш үйлдвэрлэгчид дунджаар 20000 гаруй ширхэг түлш үйлдвэрлэн хэрэглэгчдэд нийлүүлээ. Мөн хийгээр болон цахилгаанаар ажилладаг гэрийн зуухыг шинээр үйлдвэрлэн туршилтаар тавьж, энэ зуухыг олон айл өрхүүдийг хамруулах зорилгоор төсөл боловсруулан Аялал жуулчлал, байгаль орчны яаманд хүргүүлээ. Агаарын болон орчны бохирдлын аймгийн дэд хөтөлбөр 2009 онд батлуулан хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө Баянхонгор сумын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг цахилгаан халаагуураар халаалтаа шийдвэрлэхэд тарифт тоолуурын ситемд оруулах ажлыг зохион байгуулж байна. /Хэрэгжих шатандаа-90%/
21	Хөтөлбөр батлах тухай 2009.02.04 №32 /Хүнсний баталгаат байдал/	3.Нийслэл, аймаг бүр “Хүнсний баталгаат байдал” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, дүнг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	“Хүнсний баталгаат байдал” дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг Тамгын газрын даргын тушаалаар томилон ажиллуулж судалгааны ажил хийгдэж дууссан. Хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ИТХ-аар батлуулахаар бэлтгэж байна. . /Хэрэгжих шатандаа- 70%/

		даалгасугай.	
		4. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, зээл, тусламж, төсөлд хамруулан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг тодорхой тусгахаар төлөвлөж байна. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хөрөнгийн асуудлыг тусган зээл тусламж, төслөөр хийх ажлуудыг тодорхой болгон төлөвлөж, хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг тодорхой болгон төлөвлөж санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр тооцоо судалгааг гаргасан. 2009 онд жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлд хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх чиглэлээр ирүүлсэн 14 төсөл, 2010 онд 21 төслийг хамруулан дэмжлэг үзүүлэн ажиллаа. /Хэрэгжих шатандаа-70%/
22	Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр 2009.06.10 №173	2.Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллага болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрт хамруулан санхүүжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрт орон нутагт холбоотой заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа ба аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж аймгийн ИТХ-д оруулан батлуулахаар хүлээгдэж байна. Энэ хөтөлбөрт аймагт хоршоо хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардал хөрөнгийг тодорхой тусган, томъёолон гаргаж ажиллаж байна. /Хэрэгжих шатандаа- 90%/
23	2010 оныг биенсийн орчны шинэтгэлийн жил болгох тухай 2009.12.30 №377	4.“Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-ийн хүрээнд эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, төрийн байгууллагуудаас хувийн хэвшил, иргэдэд үзүүлэх үйлчилгээг “Нэг цонх” “Нэг цэг”-ийн зарчимд шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	“Бизнесийн тааламжтай орчин бүрдүүлэх жилийн ажлын төлөвлөгөө”-г аймгийн Засаг даргын 2010 оны 151-р захирамжаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд нийт 25 ажил, үйлчилгээ төлөвлөгдөн хийгдэж байгаагаас эхний хагас жилийн байдлаар 8 ажил бүрэн биелэгдэж бусад ажлууд хэрэгжих шатандаа байна. Мөн энэ ажлын хүрээнд аймгийн Засаг дарга бизнес эрхлэгчдийн хамтарсан уулзалт ярилцлага зохион байгуулж ХААН банктай хамтарч “Бизнесийн орчныг шинэтгэх нь...” аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн хийлээ. /Хэрэгжих шатандаа-50%/
24	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай 2010.06.02 №138	4.2010 оноос эхлэн Улаанбаатар хотод 12.0 мянган тонн, Дархан, Эрдэнэт хотод тус бүр 1.0 мянган тонн, бусад аймаг төвүүдэд 100 тонноос доошгүй хэмжээний мах нөөцлөн, жил бүрийн хаврын	Аймгийн төвд хувиараа бизнес эрхлэгчид хамтран 3 газарт 60 тн богийн мах, 20 гаруй тонн бодын мах нөөцлөн дотооддоо болон Улаанбаатарын зах зээлд нийлүүлэн ажилласан байна. /Хэрэгжих шатандаа-70%/

		улиралд борлуулах ажлыг зохион байгуулж байхыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	
		5.Хаврын улиралд борлуулах нөөц махны урамшуулалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг ...аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Аймгийн хэмжээнд тогтвортой мах бэлтгэдэг Аж ахуй нэгж, шаардлага хангасан мах хадгалах агуулах, зоорь байхгүй. Мөн мах бэлтгэхэд зориулагдсан хөрөнгө мөнгө төлөвлөгддөггүй, зэрэг шалтгаанаас болон энэ ажил хийгдээгүй болно.2011 оноос аймгийн төвд 2 махны үйлдвэр ашиглалтад орохоор энэ ажил хийгдэж эхэлнэ. 2011 оны төсөвт мах нөөцлөх ажилд зориулж 50,0 төгрөг суулгасан. /Хугацаа болоогүй/
Дэд бүтэц барилга хот байгуулалт			
25	Хөтөлбөр хэрэгжүүлэх талаар авах арга зарим хэмжээний тухай. 2006-08-02 №191	2.Бондын хөрөнгөөр санхүүжигдэн барих орон сууцны газрын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн Газрын “40000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд бага дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах зориулалттай 30 айлын орон сууцны барилгын газрыг шийдвэрлэв. Орон сууцны хөтөлбөрийн газартай хамтран аймгийн ЗДТГазраас Бондын хөрөнгөөр санхүүжигдэн баригдах орон сууцны болон холбогдох асуудлаар зөвлөгөөн, семинар 2 удаа зохион байгууллаа. Аймгийн Ерөнхий төлөвлөгөөний дагуу “Хонгор-1000” орон сууцны хороолол барих хэсэгчилсэн төлөвлөгөө гарган газрын байршлыг сонгон 560 айлын орон сууцны гадна инженерийн шугамын зураг төсвийг Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэв. ОССК-н хөрөнгө оруулалтаар баригдах 20айлын орон сууцны барилгын газар болон гадна инженерийн шугам сүлжээний асуудал шийдвэрлэгдсэн. /Биелэсэн- 100%/
26	Барилга, дэд бүтцийн салбарт авах зарим арга хэмжээний тухай 2007-10-31 №282	5а. Нийслэл болон аймаг, бүсийн тулгуур төв хот, сум суурин газрын нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг төслийг дэс дараатай боловсруулах, нийслэлийн нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2008 онд багтаан боловсруулж, мөрдүүлэх	3 бүсийн мужлалд 7,8,9 баллын зэрэглэлд хамаардаг иргэний хамгаалалтын зураглалыг одоогийн байдлаар ашиглаж байна. /Биелэсэн -100%/
		5в. Барилга, авто зам, эрчим хүчний байгууламжийг бүртгэж, паспортжуулах журмыг 2008 онд багтаан шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх.	Барилга байгууламжийг бүртгэх барилгын хувийн хэргийг аймгийн төв болон сумдын төсвийн байгууллагуудад хөтлүүлж, мөн хувийн хэргийг цахим хэлбэрт шилжүүлэх ажил хийгдэж байна. ЗТБХБСайдын 2009 оны 71-р тогтоолоор батлагдсан барилга байгууламжийн хувийн хэргийг шинэчлэх, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд эхний ээлжинд төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжуудыг бүртгэх 500 гаруй хувийн хэргүүдийг тарааж 75 хувьтай байна. Мөн бүртгэх зааврыг өгч, хөтлүүлэх, цахим мэдээллийн санд бүртгэх ажил эхлэхээр бэлтгэл ажил хангагдаад байна. /Хэрэгжих шатандаа-90%/

27	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр 2009.05.27 №157	2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг хандивлагч орнуудын зээл тусламжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, жил бүрийн улсын төсөвт тусгах замаар санхүүжүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х. Баттулга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Засаг даргын 2010 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 36 дугаар захирамжаар “Ажлын хэсэг” байгуулан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан гамшгаас урьдчилан сэргийлэх судалгаа, сургалт явуулах, үед авран хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. /Биелсэн- 100%/
28	Түлш эрчим хүчний салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2010.07.07 №188	5.Аймгийн төв сумдын эрчим хүчний үйлдвэрийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулж нүүрс нөөцлөх, түлш шатахуунтатан авах ажлыг зохион байгуулан өөрийн нутаг дэвсгэр дээр бйагаа цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, дулааны шугам, аваарийн болон сумдын дизель станцын засварыг графикт хугацаанд нь чанартай хийж дуусгахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай	Аймгийн төвд КАТ3508 маркийн дизель 1, ДСА 125 дизель 2 бэлэн байна, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын засвар үйлчилгээг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Төвлөрсөн уурын зуух 8 ажиллаж байгаа бөгөөд 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангаж зуух тус бүр 50-250м газарт дулааны шугам сүлжээг шинэчилэн сайжруулж 50-400 тн нүүрсний нөөцтэй ажиллаж байна. /Хэрэгжих шатандаа-90%/
29	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай 2010.07.14 №190	2.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл,эзэмшигчээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, нийслэл, сум ,дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагад хандивлаж байгаа болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гаргаж,	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулсан 12 аж ахуй нэгжийн орон нутгийн төсөвт төлсөн татвар төлбөр хураамжийн тайланг хүлээн авч нэгтгэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын албанд 2010 оны 3 дугаар сарын 31-нд хүргүүлсэн /Биелсэн 100%/

		нийтэд мэдээлж, журмын дагуу тайлагнаж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	
30	Зам, тээвэр, барилга нийтийн аж ахуй салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим	2.Орон нутгийн тээвэр болон барилга, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагын өвлийн бэлтгэлийг хангуулж, түлээ, нүүрс нөөцлөх, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл татан авах ажлыг зохион байгуулах, төв суурин газрын барилга байгууламж, орон сууцны цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний ээлжитзасвар үйлчилгээ, угаалга туршилт, авто замын засвар арчлалтыг төлөвлөсөн хугацаанд нь хийж дуусгах арга хэмжээ авахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Баянхонгор сумын хэмжээнд 2010 онд төвлөрсөн уурын зуух 8, бага оврын 121 уурын зуух үйл ажиллагаа явуулж байна. ИТХ-ын 76-р тогтоол, аймгийн Засаг даргын ... захрамжаар төвлөрсөн уурын зуух, албан байгууллагуудыг өвөлжилтийн бэлтгэл ажил хангах талаар үүрэг өгсөн. Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар хамтран 9 дүгээр сарын 8-10-ны хоронд шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 337053м3 талбайг нийт 108000 м3 талбай халаах хүчин чадлаар халааж ажиллаж байна. Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нам даралтын зуухтай иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг төвлөрсөн зууханд холбох талаар Аймгийн ИТХ-ын шийдвэр гаргуулсаны үр дүнд 41 байгууллага, иргэнд үүрэг өгч 23 байгууллага, аж ахуйн нэгж төвлөрсөн халаалтанд холбогдоод байна. /Хэрэгжих шатандаа-90%/
Эрүүл мэнд, спорт			
31	Нийтийн биеийн тамир, спортын талаар авах арга хэмжээний тухай 2009.01.07 №05	6.1.Иргэд биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулан гүйлт, алхалтын зам, дасгал, хөдөлгөөн хийх ногоон байгууламж бүхий ил талбай байгуулж, өвлийн улиралд байгалийн болон хиймэл мөс, цасан талбайг харъя нутаг дэвсгэрийнхээ орон сууц, гэр хорооллын орчимд байгуулж, тогтмол ажиллах.	Тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг Засаг даргын 503-р захирамжаар баталж, Сумдын Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн ба аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулсан бүтээгдхүүн нийлүүлэх 2010 оны гэрээнд оруулав. Хэрэгжилтэд хяналт тавин, сумдаас тухайн сард хийсэн ажлын тайланг авч Нийгтийн хөгжлийн хэлтэс нэгтгэж байна. -Биеийн Тамир спортын Газрын гадна талбайд 100,0 /Нэг зуун сая/ төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөл бөмбөгийн орчин үеийн стандартын ногоон талбайг хийж ашиглалтад оруулсан. -Мэргэжил Сургалт үйлдвэрийн төвийн гадна талбайд нийтийн биеийн тамирын стандартын талбай, жижиг цэнгэлдэх хүрээлэн, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний “Бат-Идэр” ХХКомпанитай хамтарч ажилчдын сагсан бөмбөгийн гадна талбай, Эрдэнэмандал ахлах сургуулийн гадна сагсан бөмбөгийн талбай, ОБХэлтсийн дэргэд сагсан бөмбөг, гар бөмбөгийн задгай талбайг шинээр барьж байгуулсан. - Гэр хорооллыг олон нийтийн санаачлагаар хөгжүүлэх төслийн хүрээнд Баянхонгор сумын 1,6,7 дугаар багийн иргэдтэй хамтарч спорт тоглоомын гадна талбайг байгуулсан. /Биелсэн- 100%/
32	Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний хоёр дахь хөтөлбөр	2.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг	2010 онд ЭМС-ын төсөвт эрүүл мэндийн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэхэд 80 сая төгрөг суугдсан. Энэ санхүүжилтийг ЭМГ, сум, сум дундын эмнэлгүүдэд нийгмийн

	батлах тухай 2009.09.30 №303	2010 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогт, эрүүл мэндийн сайд С.Ламбаа, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор хуваарилан зарцуулж байна. /Биелсэн- 100%/
33	Үндэсний спортын IY их наадмыг 2010 онд зохион байгуулах тухай 2009.07.14 №211	1.Монголын Үндэсний спортын IY их наадмыг 2010 онд орон даяар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Монголын Үндэсний спортын IY их наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулах комиссыг Засаг даргын 2010 оны 75 дугаар захирамжаар байгуулан ажлын төлөвлгөө боловсруулан их наадмын 1, 2-р шатыг зохион байгуулж, шалгарсан баг, тамирчид 3 дахь шатны их наадамд Ховд аймагт болсон уран уургач, бугуйлч, эмнэг сургалтын улсын аврага шалгаруулах тэмцээнд 3 тамирчин оролцож, хүрэл медаль 1, 2 тамирчин шагналт байранд орсон амжилт үзүүллээ. Үндэсний спортын IY их наадмыг зохион байгуулахад “Нийгмийн салбарын хөгжлийн хөтөлбөр”-ийн зардлаас 200,0 мянган төгрөгийг, 800,0 төгрөгийг БТСГ-ын уралдаан тэмцээний зардлаас санхүүжүүлсэн, /Биелсэн- 100%/
34	Эрүүл мэндийн даатгалын 2010 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай 2009.12.30 №374	2.Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцдаг даатгуулагчийн сарын шимтгэлийн хэмжээг 670 төгрөгөөр, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11-д заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 500 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний сарын шимтгэлийн хэмжээг 4000 төгрөгөөр тус тус тогтоож, 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй	Эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийг энэ тогтоолд заасны дагуу 2010 оны 1-р сарын 1-нээс мөрдөж эхэлсэн. /Биелэсэн- 100%/
35	Үндэсний стратегийг сайшаах тухай 2009.07.29 №239	2.Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги” Үндэсний стратегийн зорилт болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын	“Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг ЭМГ-ын нийгмийн эрүүл мэндийн алба боловруулан мөрдөн ажиллаж байна. Аймгийн Засаг даргад эрхлэх асуудлын хүрээний алба, хэлтэс, газрын дарга болон сумын Засаг дарга нараас нийлүүлэх бүтээгдэхүүний гэрээнд ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж байх талаар тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна

		гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	/Хэрэгжих шатандаа- 90%/
36	Үндэсний стратеги төлөвлөгөөний тухай 2010.02.17 №43	3.Үндэсний стратеги төлөвлөгөөг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратегийг хэрэгжүүлэх аймгийн салбар хороог аймгийн Засаг даргын 2010 оны 114 дугаар захирамжаар байгуулан, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. 2010 оны 05 сарын 06-07-нд Үндэсний хорооны гишүүд салбар зөвлөлийн гишүүдэд сургалт хийсэн. 2010-2012 онд үндэсний стратегийг хэрэгжүүлэх матрицийг боловсруулан ажиллаж байна. /Хэрэгжих шатандаа-90%/
37	Хүүхдийн спортын IY их наадам зохион байгуулах тухай 2010.08.18 №210	2.Их наадмын анхан шатны уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг 2011 оны төсөвтөө тусган аймаг, орон нутгийн хэмжээнд зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт, бүсийн болон шигшээ багуудын тэмцээн зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн сайдын 2011 оны төсвийн багцад тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа нарт тус тус үүрэг болгосугай.	Монголын хүүхдийн спортын IY их наадмын хүрээнд 2010 оны 10 дугаар сарын 23-нд ширээний теннисний анхдугаар сорил тэмцээн, 11 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд волейболын өсвөр үеийн анхан шатны сорил тэмцээн,12 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд чөлөөт бөхийн анхан шатны сорил тэмцээнүүдийг зохих журмын дагуу тус тус амжилттай зохион байгууллаа. Тус үйл ажиллагааг зохион байгуулахад нийт 800,0 мянган төгрөг зарцуулсан байна. /Хэрэгжих шатандаа-90%/
Боловсрол, соёл, шинжлэх ухаан			
38	Барилгын салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх тухай 2009.01.28 №23	2.“100 мянган орон сууц” хөтөлбөрийн төслийн хүрээнд мэргэжилтэй ажилчин бэлтгэх төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөв, холбогдох тусгай зориулалтын сан, зээл тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх төлөвлөгөөний дагуу аймгийн МСҮТ-д барилгын салбарын мэргэжилтэй ажилчид бэлтгэгдэж байна. Ажил мэргэжилгүй, өрхийн орлогогүй залуучуудад мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай болгохын тулд 2009-2010 оны хичээлийн жилд 1 жилийн ангийг шинээр нээн хичээллүүлж барилгын сантехникийн засвар гагнуурчины ангид 21, барилгын өрөгч, угсрагчийн ангид 28, токарь фрезерийн ангид 17 иргэн суралцаж төгссөн байна. Суралцах хугацаандаа мэргэжлийн хичээлийг нарийвчлан судалж, барилгын компаниудад дадлага хийсэн бөгөөд 70 хувь нь ажлын байраар хангагдсан бөгөөд 2010 оны хичээлийн жилд 646 хүүхэд шинээр элсэн суралцаж байна. /Хэрэгжих шатандаа -90%/

39	Хөтөлбөр батлах тухай 2010.02.03 №31 /Боловсрол/	2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай	Боловсрол дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг аймгийн Засаг даргын 2010 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 254 дүгээр захирамжаар томилогдсон Аймгийн Засаг даргын тамгын газар Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсрол соёлын газар хамтран Баянхонгор аймгийн боловсролын салбарт хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг /2010-2015/ боловсруулан 07дугаар сарын 01-нд аймгийн ИТХ-аар хэлэлцэгдэн 9/1 тоот тогтоолоор батлагдсан. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6 үндсэн зорилт 61 заалт бүхий төлөвлөгөөг батлан гаргасан ба 2010 оны байдлаар 24 ажил төлөвлөн 91% -тай хэрэгжүүлээд байна. /Хэрэгжих шатандаа-90%/
39	Журам батлах тухай 2010.07.07 №172 /Түүхэн ой, өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах тухай/	2.Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ...сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Түүхэн ой, өдөр, гавьяат үйлстнийг алдаршуулах ажлыг тусгай төлөвлөгөө гарган тэмдэглэх ажлыг зохион байгуулж байна.Аймгийн хэмжээнд 11 сургуулийн 70 жилийн ойг тэмдэглэж, ойн ажлын хүрээнд 70 бүтээлч ажил хийх хөдөлгөөн өрнүүлж ажиллаа.Доктор, профессор С.Лувсанвандангийн мэндэлсэний 78 жилийн ойд зориулан аймгийн ХДТ-т 35 сая төгрөгийн гадна тохижилт засварын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн Төрийн шагналт, зохиолч Ч.Лхамсүрэнгийн хөшөөг аймгийн төвд бүтээн босгосон.Салбарын тэмдэглэлт өдрийг тухайн байгууллагууд жил бүр уламжлал болгон тэмдэглэж хэвшсэн. /Биелсэн 100%/
Нийгэм хамгаалал			
40	Ажлын байрны аттестатчилалын дүнгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2009.04.22 №122	1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн түншлэлийн талууд, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах.	Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссыг Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулсан. Аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол гарах нь харьцангуй бага. Харин гар аргаар алт олборлож байгаа газруудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа зөрчигдөж шороонд дарагдсанаар амь насаа алдаж, хөгжлийн бэрхшээлтэй болох зэрэг сөрөг үр дагавар их гарсаар байна. Аймгийн ИТХ-ын тогтоол гаргаж шинээр газар эзэмшүүлэхгүй байх, гар аргаар алт олборлогчид эрүүл газрыг ухахгүй байх чиглэлээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны ажлын хэсэг нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн оролцоотойгоор Эрчим хүч, барилгын салбарын болон жижиг дунд үйлдвэрлэлийн ажиллагсдын дунд 24 цагийн сургалт зохион байгуулж ажилласан /Хэрэгжих шатандаа- 90%/
		2.Аймгийн төвийн байгууллага, орон сууцны халаалтыг нэгдсэн системд шат дараатайгаар оруулах, нам даралтын зуухны тоог цөөрүүлэх, тэдгээрт ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах.	Аймгийн төвийн орон сууцнууд халаалтын нэгдсэн системд холбогдсон. Аймгийн төвд 44 байгууллага, сумдын төсвийн байгууллагад 108 нам даралтын халаалтын зуух тус тус ашиглаж байгаа ба нам даралтын зууханд ажиллаж байгаа ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах болон ажлын цагийн хөлсийг нэмэгдүүлэх талаар хариуцагч байгууллагуудын дарга нарт мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлсэн. Мөн нам даралтын зуухаар ажилладаг зуухыг төвлөрсөн шугамд холбуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын болон ахуйн байрыг төхөөрөмжлөх талаар ИТХурлын тэргүүлэгчдийн 2010.04.30-ны өдрийн 76 дугаар тогтоол гарч, аймгийн

			Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн салбар хорооноос шалгалт хийж 12 нам даралтын зуухыг төвлөрсөн халаалтын системд холбуулсан. /Биелэсэн-100%/
41	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндэсний хөтөлбөр 2009.12.23 №371	4. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж дүнг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн 2010 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанд оруулан батлуулсан. Дэд хөтөлбөр бүх сумдад хүргэгдэж энэ талаар мэдээ, мэдээлэл, зөвлөгөө, сургалтыг байнга хийж байна. Хэрэгжилттэй холбоотой асуудлыг төвд хүсэлт болгон тавьж, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас шаардсан судалгааг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. /Биелсэн -100%/
42	Иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2010.01.06 №03	8. Иргэний шинэчилсэн бүртгэлд Монгол улсын иргэнийг бүртгэх, Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх ажлыг зохион байгуулахад улсын бүртгэл болон нийгмийн халамжийн байгууллагад бүх талын дэмжлэг үзүүлж, бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлагатай хүний нөөц, хөрөнгө гарган ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Иргэнд хишиг, хувь хүртээх ажлыг зохион байгуулах нээлтийн арга хэмжээнд аймгийн Засаг дарга, болон удирдах ажилтнууд оролцон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан, бүх сумын Засаг дарга, нийгмийн ажилтнуудад программын сургалтад хамруулан, иргэдэд хөнгөн шуурхай чирэгдэлгүйгээр тус ажлыг зохион байгуулсан. Нийгмийн халамжийн ажилтнуудад илүү цагийн хөлсийг олгосон. /Биелсэн-100%/
43	Хөрөнгө гаргах тухай 2010.03.03 №51	Хүний хөгжил сан'-аас иргэн бүрт хишиг хувь хүртээх ажлыг өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт иргэдийн аюулгүй байдлыг хангаж сахилга, дэг журмыг сахиулах талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга Д.Сандаг – Очирт даалгасугай	“Хүний хөгжлийн сан”-аас олгох хишиг, хувь хүртээх ажлыг сум бүр өндөр түвшинд зохион байгуулсаны үр дүнд Хүний хөгжил сангийн хувь хишгийг 81149 хүнд 8549080 ,0 мянган төгрөгийг олгосон. . Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагаа 0-16 насных 99,7 хувь, 16-аас дээш насных 95,1 хувьтай явагдаж байна. /Биелсэн-100%/
44	Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар авах арга хэмжээний тухай 2010.04.02 №84	7.Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулахыг Засгийн газрын гүшүүдэд , дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран	Аймгийн иргэний баримт бичгийн үзлэгийн комиссоос санаачлан үзлэгийн явц болон иргэдийг идэвхтэй оролцуулах зорилгоор телевизийн шууд нэвтрүүлэг зохион байгуулан нийтэд мэдээлсэн. Нэвтрүүлэгт Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс, Багийн Засаг дарга нар, Цагдаагийн хэлтэс зэрэг үзлэг зохион байгуулах газруудын хариуцсан мэргэжилтнүүд оролцсон. Мөн орон нутгийн сонин хэвлэлээр мэдээлсэн болно. Энэ талаар иргэдийн мэдээлэлээр бүрэн хангагдсан.

		зохион байгуулахыг аймаг нийслэлийн засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	/Биелсэн-100%/
45	Төлөвлөгөө батлах тухай 2010.04.14 №91	2.Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгах, гадаадын зээл, тусламжийн хүрээнд санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Сангийн сайд С.Баярцогт, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	/Биелсэн-100%/
46	Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар авах арга хэмжээний тухай 2010.08.18 №212	4.Аймаг нийслэлээс Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцах ажилгүй иргэдийн квотыг тогтоон аймаг нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлэхийг ...сайд-д, уг квотыг үндэслэн ажилгүй иргэдээ сургалтад хамруулах арга хэмжээг сайтар зохион байгуулах, энэхүү сургалтад хамрагдах нь иргэдэд дэмжлэг туслалцаа үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	“Оюу толгой” ХХК–ний хөрөнгө оруулалтаар үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажил зуучлах ажлын хүрээнд БСШУСайд болон НХХСайдын хамтарсан 2010 оны 409/123 тушаалаар баталсан журмын дагуу ажлын хэсэг байгуулан, бүх сумдад албан бичиг хүргүүлэн, 455 хүн бүртгэж, шалгалтыг 11-р сарын 20-нд шалгалт авах талаар бүх бүртгүүлсэн хүнд утсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл хүргүүлсэн. Ажлын хэсэг, Үйлдвэрчний зөвлөл, ажил олгогч эздийн холбоотой хамтран шалгалт авах ажлыг зохион байгуулсан ба 283 хүн 4 мэргэжлээр шалгалт өгч, 80 хүнийг сонгон шалгаруулж сургалтын үйл ажиллагааг 2011 оны 1-р сарын 3-наас эхлүүлсэн. /Биелсэн-100%/
Төрийн захиргаа удирдлага			
47	Хөтөлбөр батлах тухай 2008-01-09 №07 /Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр/	3. Хөтөлбөрийн хүрээнд 2008-2010 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хүрэх үр дүн болон шаардагдах зардлын төсвийн төслийг ...аймгуудад хүргүүлэхийг...даалгаж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хүрэх үр дүн болон шаардагдах зардлын төсвийн төсөл ирээгүй байна. /Хугацаа болоогүй/
		4. “Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг орон нутгийнхаа онцлогт тохируулан боловсруулж	Жишиг сум, жишиг баг шалгаруулах болзол зарлаж, сумыг Засаг дарга нарт хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна. Энэхүү арга хэмжээнд сумын Засаг дарга нар ихээхэн ач холбогдол өгч ажиллаж байгаа бөгөөд багуудыг “Жишиг баг” хөтөлбөрт хамруулан

		хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт, орон нутгийнхаа нөхцөлд тохирсон жишиг багийг сум болгонд 2008 онд багтаан бий болгож, багаа ээлж дараатай тохижуулах арга хэмжээ авахыг аймаг, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.	болзолын журамд тусгагдсан шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгээр тодорхойлогдсон гол ажлуудыг хийгээд байна. Тухайлбал багийн төвийн барилгуудад их засвар хийдсэн, тэжээлийн агуулах, хайс хамгаалалт баригдсан, багийн дарга нарын хариуцлагыг өндөржүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх үүднээс унаа, компьютерээр хангаж ажиллаж байна. /Биелсэн -100%/
48	Хяналт шинжилгээ, үнэлгээний журам шинэчлэн батлах тухай 2010.01.13 №11	2.Засгийн газрын агентлаг, сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмыг баталж, мөрдүүлэхийг сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журмыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Мөн Монол улсын Засгийн газрын 2010 оны “Хяналт шинжилгээ, үнэлгээний журам шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг нэгтгэн хүргүүлж байна. /Биелсэн- 100%/
49	Монгол Улсын хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэд эхний шатны үнэлгээ хийх төлөвлөгөө батлах тухай 2010.04.14 №95	2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэнд 2010 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар эхний шатны үнэлгээ хийх бэлтгэлийг хангах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Тус төлөвлөгөөнд тусгагдсан аймагт хэрэгжүүлэх боломжтой заалтуудыг харъяа хэлтэс, алба, газруудад санал авахаар хүргүүлээд байна. / Хэрэгжих шатандаа-30%/
50	Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай 2010.09.15 №237	3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг баталсан шийдвэрээ хүчингүй болсонд тооцохыг Засгийн газрын гишүүд, аймгийн Засаг дарга нарт даалгаж, аймгийн ИТХТэргүүлэгчдэд зөвлөсүгэй	Иргэний бүртгэлийн үйлчилгээний үнэ тарифын хэмжээг тогтоосон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 114 дүгээр тогтоолыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 198 дугаар тогтоолоор хүчингүй болгуулан ажиллалаа. /Биелсэн -100%/
Хууль хяналт			
51	Журам батлах тухай 2009.01.28 №28	2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусган шийдвэрлэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцос аймгийн хэмжээнд гараагүй байгаа бөгөөд хэрэв ийм цогцос гарвал шүүх эмнэлгийн магадлан шинжилгээ хийх, түүнийг хадгалах, оршуулах болон бусад холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс гаргах боломжтой. /Хэрэгжилт-100%/
52	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2010.10.06	2.Төрийн архивын мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан нэгдсэн сан байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор төрийн архивуудад	Аймгийн Төрийн архивыг мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан нэгдсэн санд оруулах зорилгоор сервертэй болох, цаасан баримтыг цахим сангийн баримтад шилжүүлэхэд ажиллах шаардлагатай операторч нарыг ажиллуулах тухай заалтыг аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2011 оны үндсэн чиглэлд тусган батлуулсан.

	№261 /Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх/	гэрээгээр 175 операторч ажиллуулахад шаардагдах цалингийн сан болон тоног төхөөрөмжийн зардлыг 2011 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг ...сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасаугай.	/Биелсэн-100%/
		Батлан хамгаалах	
53	Ой тэмдэглэх тухай 2008.06.27 №272	10. Халх голын байлдаанд оролцсон ахмад дайчдыг төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах ажлыг зохион байгуулах.	1945 оны чөлөөлөх дайнд оролцож, ялалт байгуулсан түүхт 65 жилийн ойг аймаг, нутгийн захиргааны болон төрийн байгууллага, сум орон нутгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх тухай аймгийн Засаг даргын 383 дугаар захирамж гаргаж дайнд оролцсон 14 ахмад дайчны дайнд гүйцэтгэсэн үүрэг, байгуулсан гавъяа, шагнал үйл хэргийнх нь талаар тодорхойлолт гарган ойг зохион байгуулах комисст хүргүүлж ахмад дайчин Гомбосүрэнгийн Готов, Гэндэндоржийн Жамц нарыг "Цэргийн гавъяаны одон"-гоор, бүх ахмад дайчдыг "Чөлөөлөх дайны ялалтын 65 жилийн ойн медалиар шагнасан" хүн бүрт олгож баяр хүргэв. / Биелсэн 100%/
54	Төлөвлөгөө батлах тухай 2010.02.17 №40	2.Терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулан хэрэгжүүлж ажиллахыг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн ажлын хүрээнд: -Аймгийн 8 онцгой объектын аюулгүй байдалд үзлэг шалгалт хийхэд ноцтой зөрчил илрээгүй ба болзошгүй халдлага, осол сүйрлээс урьдчилан сэргийлэх талаар үүрэг чиглэл өгсөн. -Иргэний хөдөлгөөнүүдийн зүгээс нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэж болзошгүй нөхцөл үүссэнтэй холбогдуулан захиргааны болон гүйцэтгэх ажлын шугамаар холбогдох арга хэмжээг авсны үр дүнд нөхцөл байдлыг хяналтанд авч, гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан. /Хэрэгжих шатандаа- 90%/
Монгол Улсын Засгийн Газрын албан даалгавар			
Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж			
Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж.			
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл			
Үйлдвэр худалдаа			
1	2007-09-19. №44	2. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, арьс шир, түүхий эдийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг авч ажиллахыг ... сайд аймаг ... Засаг дарга нарт даалгав.	Аймгийн Цөм сүргийн үржлийн төвийг Байдраг үүлдрийн нарийн нарийвтар ноосны хонь үржүүлэх чиглэлээр оны эхэнд шинээр байгууллаа.Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар ВС-Монгол компаниас лизингээр Галуут суманд 10 торгууд хуц, Өлзийт суманд 8 барга хуц, Жинст суманд АНУ-ын махны хэвшлийн суффольк хуц 1-ийг тус тус захиалгаар нийлүүллээ. Мөн Баацагаан, Баян-Овоо суманд энэ чиглэлийн хээлтүүлэгчийн захиалга авлаа. Хүрээмарал суманд Баяд хуц 20, Баянбулаг суманд баяд хуц 50, Бөмбөгөр

			<p>суманд Өлгийн улаан ухна 10, Баяд хуц 10, Сэлэнгэ үүлдрийн мах сүүний чиглэлийн 6 охин шүдлэн үхэр, бух 1-ийг тус тус авлаа. Баянцагаан суманд хурдан хэвшлийн адуу 6, Хэнтийн Галшарын адуу 4, Баян-Овоо суманд сүүний чиглэлийн Алатау үүлдрийн бух 1, гунж 1 –ийг тус тус авч байгаль экологийн нөхцөлд дасан зохицох чадварыг туршиж байна.</p> <p>Куба улсын , “Альпан”, Шведийн “Тогенбург үүлдрийн ухнын гүн хөлдөөсөн үр 100 тунг захиалан авчирч цөм сүргийн 25 ямаанд зохиомол хээлтүүлэг хийсэн. Мөн Өвөрхангай аймгаас нутгийн шилмэл 100 ухна, 40 хуцийг авч Өлзийт сумын малчидад гэрээгээр олгосон.</p> <p>Мал эмнэлэг, үржлийн арга хэмжээг жил бүр аймгийн Засаг даргын шийдвэрийн дагуу хийж 2010 оны байдлаар хадлварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд 1.8 сая, малын үзлэг ангилалтанд 350 мянган мал хамруулаад байна.</p> <p style="text-align: right;">/Биелсэн -100%/</p>
		Хууль хяналт	
2	2010.04.07 №21	<p>4.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх гзрын хамтарсан ажлын хэсгээс “Авлигаас урьдачлан сэргийлэх үйл ажиллагааны 2009 оны төлөвлөгөө” –ний хэрэгжилттэй холбоотой дараах асуудлуудад анхаарч ажиллахыг ... аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав .</p> <p>4.1.Авлигаас урьдачлан сэргийлэх үйл ажиллагааг байгууллагынхаа онцлогт тохируулан судалгааны үндсэн дээр бодитой төлөвлөж тэдгээрийг хэрэгжүүлэх талаар удирдлагын манлайллыг сайжруулах</p>	<p>2010 онд аймгийн хэмжээнд авилгын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд иргэдийг татан оролцуулах авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсоход чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах ажлын хэсгийг хууль хяналт, авилгад өртөж болзошгүй эрсдэлтэй байгууллагын дарга нар, сумдын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, аймгийн Засаг даргын 2010 оны 281 дүгээр захирамжаар батлуулан, ажлын хэсгийн ажиллах журмыг батлуулан мөрдөн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжих шатандаа-90%/</p>
		4.2.Авлигаас урьдачлан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх түүнд хяналт тавих тайлагнах асуудлыг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авилгатай тэмцэх газар болон АНУ-ын Азийн сангаас зохион байгуулсан семинараас гарсан зөвлөмжийн дагуу тус аймагт авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулж төлөвлөгөөний дагуу ажилласан.</p> <p style="text-align: right;">// Биелсэн 100%/</p>
		4.3. Салбарын хэмжээний болон эрхлэх ажлынхаа хүрээний байгууллагуудын авлигаас урьдачлан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжилтийг хагас бүтэн жилээр дүгнэн нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	<p>2010 оны төлөвлөгөөний биелэлтийг тооцон дүгнэж, нэгдсэн тайланг Засгийн газрын ХЭГ-т хүргүүлэхээр ажиллаж байна..</p> <p style="text-align: right;">/ Биелсэн 100%/</p>

3	2010.04.07 №21	1.1.Улсын Их Хурлын 2003 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж эрхэлсэн ажлын хүрээ нутаг дэвсгэрийн хэмжээнд уг хөтөлбөрийн үндсэн чиглэл зарчимд нийцүүлэн нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллахыг ... аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Аймгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг аймгийн ГХУСА33-ийн гишүүд болон холбогдох байгууллагуудад танилцуулан саналыг авч, төлөвлөгөөнд тусган Зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Төлөвлөгөөг аймгийн ГХУСА33-ийн 2010 оны 12 дугаар сарын 15-ны 07 дугаар тогтоолоор батлуулан, биелэлтийг зохион байгуулан ажиллаж байна. \Хэрэгжих шатандаа- 90%/
4	2010.05.19 №28	3.1.Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, төрийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг байнга авч ажиллан, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянаж бүртгэх эрх зүйн зохицуулалтыг үйл ажиллагаандаа мөрдөж хэвшүүлэх	Засгийн Газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ыг мөрдөн ажиллаж байна. Дээрх журмаар 20 сумын Засаг дарга, түүний Тамгын газрын дарга нарт 1.30 цагийн сургалт хийж, журмыг бүх сумдад хүргүүлсэн. / Биелсэн 100%/
		3.2.Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр баталсан хууль тогтоомжид нийцүүлэн тэдгээрт тухай бүрт нь нэмэлт өөрчлөлт оруулж байх	Аймгийн Засаг даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан 4 шийдвэр улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байгаа. Дээрх шийдвэрүүдэд дүн шинжилгээг тогтмол хийн ажиллаж байгаа ба 2010 оны байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гараагүй болно. / Биелсэн 100%/
		3.3.Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар журам, дүрэм гаргах, хуулийр олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлэх явдлыг таслан зогсоож, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүргүүлсэн дүгнэлтийн дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллах	Засаг даргын шийдвэрүүдийг тогтмол хянан ажиллаж байгаа ба хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар журам, дүрэм гаргах, хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлэх явдал гараагүй болно. / Биелсэн 100%/
Төрийн захиргаа удирдлага			
5	2009.07.22 №49	3.5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон бусад бодлогын зорилтуудын хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг яам, Засгийн газрын агентлаг, аймаг нийслэлийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов гэжээ.	Засгийн газрын болон орон нутгийн удирдлагаас батлагдсан хөтөлбөр, төсөл, бодлогын явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зардлыг тухай бүр нь санхүүжүүлэн ажиллаж хэвшсэн. /Биелсэн -100%/
6	2008.10.22 №59	10.5.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн тухай монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор Засгийн газрын гишүүдэд танилцуулав. үүнтэй холбогдуулан 2008 оны III улиралын байдлаар тасарсан болон удааширч байгаа заалтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав гэжээ.	2008 оны III улиралын байдлаар тасарсан болон удааширч байгаа заалтуудыг хэгэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар тогтоол шийдвэрийг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2а/771 тоот албан бичгээр зөвлөмж өгч хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Шинээр ирсэн тогтоол шийдвэрийг улирал бүрийн эхэнд холбогдох мэргэжилтэн бүрт хуваарилан үйл ажиллагааны явцад хяналт тавин ажиллаж байна.

			/Биелсэн- 100%/
7	2010.02.24 №12	<p>ХИ.2. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2009 оны дүнгийн тухай Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулах Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэрийн заалт, арга хэмжээ бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд нь бодитойгоор тайлагнах, 2009 оны эцсийн байдалаар тасарсан болон хэрэгжилт нь удаширч байгаа асуудлуудыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав гэжээ.</p>	<p>Хууль тогтоомж, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, биелэлтийн талаар тайланг ирүүлэхдээ зөв, оновчтой тодорхойлох, шат шатандаа тавих хяналтыг сайжруулах талаар үүрэг, чиглэл өгч "Аймгийн Засаг даргын шийдвэр, өгсөн үүрэг даалгавар, аймгийн ИТХ, Засгийн газрын тогтоол шийдвэр, улс аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэх, хяналт тавих төлөвлөгөө"-г боловсруулан мөрдөж ажиллаж байна.</p>
			/Биелсэн 100%/
8	2010.04.28 №25	<p>2. Үндэсний хөтөлбөр төслийн хэрэгжилтийн 2009 оны явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав.</p> <p>2.1. Салбар болон үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичиг үндэсний хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж Улсын Их Хурал, Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу шинээр боловсруулах хөтөлбөр, төслийн жагсаалт гарган хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах</p>	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгийн мөрөөр хийж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Мөн үндэсний хөтөлбөр, төсөл, улс, аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, мэдээлэх төлөвлөгөөг гарган ажиллаж байна.</p>
			/Биелсэн-100%/
		<p>2.2. Засгийн газрын 2006 оны 160, 2009 оны 285, 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу тайлан мэдээ гаргаж байх</p>	<p>Сумын Засаг даргаас аймгийн Засаг даргад 2010 онд нийлүүлэх бүтээгдэхүүний гэрээнд үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг гаргахдаа Монгол улсын засгийн газрын 2009 оны 285 дугаар тогтоолын дагуу тайлан мэдээг гаргаж байх талаар тусгаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Засгийн газрын 2006 оны 160, 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу тайлан мэдээгээ өгч хэвшсэн.</p>
			/Биелсэн-100%/
		<p>2.4.Цаашид шинээр гаргах бодлогын баримт бичгийн уялдаа, холбоог сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, хэрэгжих үндэслэл, шалгуур үзүүлэлт, үе шатыг тодорхой болгох зорилгоор үндэсний хөтөлбөр, төсөлийг боловсруулахдаа Үндэсний хөгжил, шинэтгэлийн</p>	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгийн мөрөөр хийж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Цаашид шинээр гаргах баримт бичгийн уялдаа холбоог сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, хэрэгжих үндэслэл, шалгуур үзүүлэлт, үе шатыг тодорхой болгох зорилгоор шат дараалсан арга хэмжээг авч ажиллахаар</p>

		хорооноос санал авсны үндсэн дээр батлуулан шийдвэрлэж байх	төлөвлөсөн. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны сургалтад Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн семинарт орсон бөгөөд энэ үеэрээ хөтөлбөр төслийг боловсруулах талаар зөвлөмж авч, хэрэгжүүлж байна. /Биелсэн-100%/
9	2010.01.11 №3	7. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан бүх шатны Засаг дарга нарыг гадаад, дотоод томилолтоор ажиллуулахыг зогсоож, гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан тэдгээрийг удирдлагаар хангаж, хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Бүх шатны Засаг дарга нарыг гадаад, дотоод томилолтоор ажиллуулах, аймаг орон нутагт нэгдсэн семинар хийхийг хориглож, чиглэл өгч ажиллаа. Өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны “Эрсдэлгүй мал аж ахуйн төлөө” болзол батлах тухай 182, “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” 335, “Ажлын хэсэг томилох тухай” 375, “Отрын штаб зохион байгуулах тухай” 435, “Мал аж ахуйн өвөлжилтийг зохион байгуулах тухай” 452, “Оторчид эргэх тухай” 492, “Хамтран ажиллах тухай” 510 тоот захирамжууд гарснаас гадна бусад төлөвлөгөө, удирдамж боловсруулагдан бүх салбарт хүргэгдсэн. Мөн 2010 он гарсаар аймгийн Засаг даргын “Өвөлжилт, хаваржилтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 07, “Ажлын хэсэг томилох тухай” 19, “Цаг үеийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 26 тоот захирамж гарч хөдөө аж ахуйн цаг үеийн ажлуудыг эрчимжүүлэн зохих шийдвэрийг хугацаа алдалгүй гаргаж, хяналт тавин, бүх сум, баг, хороо, байгууллагын дарга нарыг удирдлагаар хангаж, явцын талаар мэдээлэл хийж ажиллаа. /Биелсэн 100%/
		Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт	
10	2010.01.20 №5	5.1. Засгийн газрын 2009 оны 3 дугаар албан даалгавраар худалдан авах ажиллагааны талаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт нь хангалтгүй байгаа тул ажлын явцыг эрчимжүүлэх зорилгоор дараар арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов. А. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу 2010 оны 2 дугаар сарын 1-ний дотор улсын хэмжээнд бүх тендерийг зарлаж, 4 дүгээр сарын 1-ний дотор тендер шалгаруулалтыг дүгнэж дуусган гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн байх	2010 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: Баянхонгор аймгийн төрийн сан, хөдөөгийн сумдын төрийн санд харилцагч банк сонгон шалгаруулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Богд сумын эмнэлгийн барилга засвар, аймгийн Засаг даргын тамгын газрын халаалтын завсар, 4-цэцэрлэгийн барилгын засвар, Эрдэнэцогт сумын соёлын төвийн завсар, Өлзийт сумын сургуулийн засвар, Баянбулаг сумын цэцэрлэгийн барилгын засвар, Галуут сумын цэцэрлэгийн барилгын засвар, Баацагаан сумын цэцэрлэгийн барилгын засвар, аймгийн төвд баригдах 75 ортой цэцэрлэгийн барилга угсралт, Галуут сумын ЗДТГ-ын барилга угсралт, Баянхонгор аймгийн төвд байгуулах жишиг агро паркийн тоног төхөөрөмж нийлүүлэх, Бууцагаан –Хүрээмарал сумын 15 кВт-ын ЦДАШ, дэд станцын ажлын барилга угсралт, Хүрээмарал-Баянбулаг сумын 15кВт-ын ЦДАШ, дэд станцын барилга угсралт, Аймгийн Засаг даргын тамгын газар хөдөөгийн сумын ЗДТГ-т автомашин компьютер тоног

			<p>төхөөрөмж нийлүүлэх, Ерөнхий боловсролын сургуулиудад компьютер тоног төхөөрөмж нийлүүлэх, Хүүхдийн төлөө хэлтэс, 4-р сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэх , Инженерийн хийцтэй уст цэг шинээр гаргах ажлуудын тендерийг зарлаж гүйцэтгэчийг сонгон шалгаруулж барилга угсралт, тоног төхөөрөмж , их засварын ажлууд хийгдэж ашиглалтад өгч байна.</p> <p>Аймгийн хэмжээнд цас их орж гамшгийн зэрэгт хүрсэн тул “Өвөлжилт хаваржилтыг даван гарах хөтөлбөр”-ын 250,0 сая төгрөгийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34,1,5 дахь заалтын дагуу шууд гэрээ байгуулж өвс тэжээлийг ОБЕГ болон Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгуудаас худалдан авч аймгийн 20 сумд газар дээр нь хүргүүлсэн.</p> <p>Бөмбөгөр, Галуут, Жинст Заг, Бууцагаан, Баацагаан, Жаргалант, Баянлиг сумдын ЗДТГ-ын албан хэрэгцээний автомашиныг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5 дахь заалтын дагуу Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын газрын зөвлөмжөөр “Хурд авто” ХХК-тай гэрээ байгуулж УАЗ -31352 маркийн авто машиныг шууд гэрээгээр худалдан авсан. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг 90 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулж дууслаа.</p> <p style="text-align: right;">/Биелсэн -100 %/</p>
		<p>Б. Тендер шалгаруулалтын үнэлгээг богино хугацаанд буюу 14 хоногт багтаан хийж дуусган гэрээ байгуулах зөвлөмжийг гаргах, тендер шалгаруулалтын онцгой журам болох харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ хууль зөрчихгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1- д заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулах</p>	<p>Тендер нээсэн хугацаанаас хойш ажлын 5 хоногт багтаан үнэлгээг хийж дүгнэн мэдэгдлийг аж ахуй нэгж байгууллагад хүргүүлж ажиллаж байна. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй байсан тул “Өвөлжилт хаваржилтыг даван гарах хөтөлбөр”-ийн 250,0 сая төгрөгийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34,1,5 дахь заалтын дагуу шууд гэрээ байгуулж өвс тэжээлийг ОБЕГ болон Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгуудаас худалдан авч аймгийн 20 суманд газар дээр нь хүргүүлсэн. Сумдын авто машин тоног төхөөрөмж худалдан авах 130,0 сая төгрөгт Бөмбөгөр, Галуут, Жинст Заг, Бууцагаан, Баацагаан, Жаргалант, Баянлиг сумдын ЗДТГ-ын албан хэрэгцээний автомашиныг шууд гэрээгээр худалдан авсан. Гурванбулаг, Заг , Жаргалант, Галуут , Бууцагаан , Баацагаан, Жинст, Бөмбөгөр сумдын нутаг дэвсгэрт цасны зузаан 20-50 см, уулархаг нутгаараа 1м хүртэл зузаан цастай, хүйтний эрч хоногт 40 градусаас дээш хэмийн, хүйтэн өдөртөө 25 хэмээс дээш хүйтэрч цасан шуурга шуурч зам даваанууд хаагдаж гамшгийн байдалд хүрсэн тул хөрөнгө оруулалтад тусгагдсан автомашиныг худалдан авах тендерийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.1.5 дахь заалтын дагуу шууд гэрээ байгуулсан. Бусад зарлагдсан байгаа</p>

			тендер шалгаруулалтыг нээлттэй болон харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтаар явуулж дууслаа. Биелсэн-100%/
		В. Тендерийн урилга, үр дүнг өдөр тутмын 2 сонинд нийтэлж, Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд /www.e2procurement.mn/ тавьж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж байх.	Богд сумын эмнэлгийн барилгын засвар, АЗДТГ-ын халаалтын засвар, Баянхонгор аймгийн төвд баригдах 75 ортой цэцэрлэгийн барилга угсралт, Галуут сумын ЗДТГ-ын конторын барилга угсралт, Ерөнхий боловсролын сургуулиудад компьютер тоног төхөөрөмж нийлүүлэх , Аймгийн ЗДТГ, хөдөөгийн сумдын ЗДТГ-т авто машин компьютер тоног төхөөрөмж нийлүүлэх, 4-р сургууль Хүүхдийн төлөө хэлтэст тоног төхөөрөмж нийлүүлэх, Баянхонгор аймгийн төвд байгуулах жишиг агропарк, , Бууцагаан –Хүрээмарал сумын 15 кВт-ын ЦДАШ, дэд станцын ажлын барилга угсралт, Хүрээмарал-Баянбулаг сумын 15кВт-ын ЦДАШ, дэд станцын барилга угсралт инженерийн хийцтэй уст цэг шинээр гаргах, аймгийн өрхийн эмнэлгүүдийн их засвар, машин тоног төхөөрөмжийн тендерүүдийн урилгыг /www.e-procurement.mn вэб хуудсанд байршуулж , Өдрийн сонин , Үнэн сонин Монцамэ мэдээ сонин, Зууны мэдээ сонин , Өнөөгийн Баянхонгор зэрэг сонинуудад байршуулж , мөн аймгийн олон нийтийн телевизийн урсдаг зараар олон нийтэд зарлаж байна. Тендерийн урилгын үр дүнг тус веб хуудаст байршуулсан. /Биелсэн-100%/
11	2010.04.14 №21	4.1.В.Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажилтнуудын мэдлэгийн түвшинг байнга дээшлүүлэх, Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Аймгийн Засаг даргын Тамгын газрын худалдан авах ажиллагааг хариуцсан мэргэжилтэн М.Наранчимэг 2010 оны 3-р сарын 27, 28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод худалдан авах ажиллагааны 3-н өдрийн сургалтанд суусан. Мөн Бүгл Найрамдах Солонгос улсад "Capacity reinforcement in Recipient Country's Procurement system for United Aid" буюу худалдан авах ажиллагааны чиглэлээр 18 хоног мэргэжил дээшлүүлсэн. Цаашид мэдлэгийн түвшин дээшлүүлэх сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллах болно. /Биелсэн-100%/
		4.1.Г. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрх үүргийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай бүрт мөн хуулийн 49.2-т заасан баримт бичиг, материалаар хавсралт хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үнэлгээний хороо байгуулан эхлээд тендерийн үйл ажиллагааг дуустал ажилд хяналт тавин ажиллаж, зарлагдсан бүх тендерүүдийн материалыг үдэж хавтаслан архивын нэгж болгон архивт шилжүүлж байна. /Биелсэн-100%/
		4.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,	Худалдан авах ажиллагааны тайланг хуулийн хугацаанд Сангийн

		ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж мөрдүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтан, байгууллагад хариуцлага тооцох, эдгээр аж ахуй нэгжийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи мэдээллийг хуульд заасны дагуу Сангийн Яаманд тайлагнаж ажиллах	яамны Худалдан авах ажиллагааны бодлогын газарт хүргүүлж байна. Зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй байна. /Биелсэн-100%/
12	2010.05.12 №27	14.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2010 оны 1 дүгээр улирлын явц үр дүнгийн талаар сангийн сайд С.Баярцогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлсэн болон зураг төсөл хийгдээгүйн улмаас төндөр шалгаруулалтын хугацаа хоцорч байгаа төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг 2010 оны 6 дугаар сарын 1-ний дотор холбогдох журмын дагуу шалгаруулж гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэх	Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын төндөр шалгаруулалт хугацаандаа зохион байгуулагдаж дууссан. /Биелсэн-100%/
		2.2.Худалдан авах арга ажиллагааны асуудал хариуцсан төрийн албан хаагчдыг давтан сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тэдний үүрэг хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авах	Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсийн худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн 2010 оны 3-р сарын 27, 28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод худалдан авах ажиллагааны 3-н өдөр мөн 5-р сарын 24-28-ны хооронд худалдан авах ажиллагааны сургагч багш бэлтгэх сургалтанд сууж сертификат авсан. Аймгийн хэмжээд худалдан авах ажиллагааны сургалтыг авах төлөвлөгөөг гаргаад ажиллаж байна. /Хэрэгжих шатандаа-90%/
		Эрүүл мэнд, спорт	
13	2006-3-22. №12	2.Монгол иргэд гадаад, дотоод явж оношлогоо, эмчилгээ хийлгэж байгаа зарим төрлийн өвчнийг өөрийн оронд оношилгоо, эмчилгээ хийлгэж байгаа зарим төрлийн өвчнийг өөрийн оронд оношлох, эмчлэх боломж нөхцлийг бүрдүүлэх зорилгоор оношилгоо, эмчилгээний төв байгуулах асуудлыг судлан хэрэгжүүлэх.	Бүсийн хөгжлийн бодлогын хүрээнд аймаг дундын “Оношилгоо, эмчилгээний төв”-ийг Өвөрхангай аймагт байгуулагдан ажиллаж байгаа. Алсын зайн оношлогооны тоног төхөөрөмжийг нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт байрлуулан, клиникийн III эмнэлэгийн оношлогооны сүлжээнд холбож, хорт хавдар, дотрын өвчнүүд эрт оношлогдож, хугацаа алдахгүй, чирэгдэлгүй оношлогдож, эмчлэгдэх боломжтой болсон. /Биелсэн -100%/
14	2007-07-04 №30	10. “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, санхүүжүүлж илрүүлэх нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг...Засаг дарга нарт үүрэг болгов.	“Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”ийн хүрээнд “ЭМСХ-2” төслөөр 20 сумын эмнэлэгт 3 төрлийн хурдавчилсан оношлогооны болон жирэмсний тест, элэгний “В” вирус илрүүлэх оношлуур, гемоглобин тодорхойлогч, шээсний оношлуур, өндөг цоологч ланцет 500-

			<p>2500 ширхэг нийт 6.5 сая төгрөгийн үнэ бүхий оношлуурыг олголоо.</p> <p>Мөн Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн тасагт 17,5 сая төгрөгний тархины цахилгаан бичлэгийн аппарат, Лабораторийн тасагт 39,0 сая төгрөгийн “Аутолайзер” биохимийн шинжилгээний иж бүрэн цахимжсан аппаратыг нийлүүлж, эмч, мэргэжилтэнг сурган, аймгийн хэмжээнд нийт 5602 хүнд, 12 төрлийн шинжилгээг хийж онош тодрууллаа. Улсын клиникийн 3-р эмнэлэгтэй хамтран Нидерландын Вант улсын дэмжлэгтэйгээр “Зүрхний цахилгаан бичлэгийг алсын зайнаас эмнэлэг хооронд дамжуулах нь” төслийг хэрэгжүүлэн шаардлагатай компьютер техник хэрэгсэл факсын аппаратаар ханган, Сум дундын 2 эмнэлэгт лаборатори, эх барих эмэгтэйчүүд, чих хамар хоолой, шүд, сэхээн амьдруулах 65 нэр төрлийн 112.2 сая төгрөгийн үнэ бүхий, аймгийн нэгдсэн эмнэлэгт лаборатори, амьсгал, зүрх судас, эх барих эмэгтэйчүүд, мэс засал, нүд, оношлогоо, эмчилгээний 86 нэр төрлийн 77.8 сая төгрөгийн өртөг бүхий стандартад заагдсан зайлшгүй шаардлагатай багаж тоног төхөөрөмж олгосны зэрэгцээ нийт сумдын 80 хувь нь хэт авиан оношлогоо ЭХО аппараттай боллоо.</p> <p style="text-align: right;">/Биелсэн -100%/</p>
15	2010.01.13 №04	3.1. Монгол улын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	<p>Донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, баримтлах бодлогыг хэрэгжүүлэх талаар Засаг даргын 2010 оны 578 –р албан бичгийг ЭМГ-т хүргүүлэн бодлогын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, Аймгийн хэмжээнд цус, цусан бүтээгдхүүнээр дамжин халдварласан өвчин бүртгэгдээгүй ба донорын цус, цусан бүтээгдхүүний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Донорын талаархи мэдлэг олгох сургалт, сурталчилгааг ард иргэдэд нэгдсэн эмнэлгийн цусны албанаас байнга хийж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжих шатандаа 90%/</p>

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН

ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТБАЯР

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.ГОМБОДОРЖ

